

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 7366 дугаарт бүртгэв.

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ХАЛИУН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 9 дүгээр
сарын 15-ны өдөр

Дугаар 10

Халиун

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14 дэх заалт, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.2 дахь хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1, 9.2.2 дахь заалт, Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 192, А/243 дугаар тушаалын 1, 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2.Хог хаягдлын хураамжийг төсөвт төвлөрүүлж, хог хаягдлын үйлчилгээг сайжруулж ажиллахыг сумын Засаг дарга (Б.Өнөржаргал)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоолыг захиргааны хэм хэмжээний актаар бүртгэгдсэн өдрөөс эхлэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 14 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Г.БАТМАГНАЙ

*Говь-Алтай аймаг Халиун сумын иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2025 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн
10 дугаар тогтоолын хавсралт*

**ХАЛИУН СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН
ХЭМЖЭЭ**

№	Хог хаягдлын үйлчилгээний хураамж төлөгч, ногдох эх үүсвэр	Хог хаягдлын үйлчилгээний хураамж төлөх хугацаа	Хураамжийн хэмжээ (төгрөг)	Тайлбар
1	Сумын төвийн айл өрх	Сар бүр	5000	Зөвхөн ахуйн хог хаягдалын хураамж. Бусад хог хаягдлыг өөрсдийн зардлаар хогийн цэгт тээвэрлэн хаяна.
2	Малчин өрх	Сар бүр	1700	
3	Худалдаа, үйлчилгээний газар болон тухайн үйл ажиллагааг явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэн.	Үйл ажиллагаа явуулж байгаа сар бүр	10000	Тухайн үйлчилгээний газар болон байгууллагын засвартай холбоотой овор хэмжээ ихтэй хогийг өөрсдийн зардлаар хогийн цэгт тээвэрлэн хаяна.
4	Төсөвт байгууллагууд	Сар бүр	10000	
5	Нэгдсэн халаалтын уурын зуух ажиллуулж байгаа аж ахуйн нэгж	Үйл ажиллагаа явуулж буй хугацаанд сар бүр. Тухайн үйл ажиллагаа явуулсаны улмаас үүссэн хог хаягдлын хураамж.	20000	Уурын зуухнаас гарсан нүүрсний үнс, нүүрсний үлдэгдэл болон овор хэмжээ ихтэй (0.75 м.кубээс дээш) хог хаягдлаас бусад ахуйн хог хаягдалд хураамж төлнө.
6	Мал нядалгааны газарт мал нядалсан аж ахуй, иргэн	Мал нядалсан тухай бүр. Мал нядалгаанаас үүссэн хог хаягдлын хураамж.	15000	Мал нядалсан аж ахуй, иргэн хог хаягдлыг цэвэрлэж, бөөгнүүлж тээвэрлэхэд бэлэн болгосон байна.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 7367 дугаарт бүртгэв.

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 9 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар 93

Улаанбаатар
хот

ДУНДГОВЬ АЙМГИЙН ГУРВАНСАЙХАН СУМЫН ТӨВИЙН УС ТҮГЭЭХ БАЙРНЫ ЦЭВЭР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.13, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.2, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Дундговь аймгийн Гурвансайхан сумын төвийн ус түгээх байрны цэвэр усны үйлчилгээний тарифыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан тарифыг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэний дараах сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг дарга /Б.Энхтуяа/-д үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Дундговь аймгийн сумдыг ус хангамжийн үйлчилгээний талаар мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллахыг “Дундговь ус” ОНӨААТҮГ /Т.Мөнхбаяр/-т даалгасугай.

4.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Үнэ тариф, судалгааны газар /Б.Доржбат/-т даалгасугай.

ДАРГА

Г.ЦОГТСАЙХАН

ГИШҮҮН

Д.АНХБАТ
Ц.БАТЗАЯА
Т.УЛАМБАЯР

*Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт,
үйлчилгээг зохицуулах хорооны 2025 оны 09 дүгээр сарын 29-ний
өдрийн 93 дугаар тогтоолын хавсралт*

ГУРВАНСАЙХАН СУМЫН ТӨВИЙН УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ

Ангилал		Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
Цэвэр ус	Ус түгээх байр	төг/л	2.72

ТӨВ АЙМГИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 7 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 18

Зуунмод

ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3, 26 дугаар зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн Төв аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч “Улаанбаатар төмөр зам” БЗАУАнгийн эзэмшлийн дулаан түгээх шугам сүлжээнд холбогдсон Батсүмбэр сумын “Мандал” өртөөний албан байгууллага болон айл өрхөд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2.Халаалтын горимыг чанд баримтлан, хэрэглэгчдийг шаардлагатай дулаанаар хангаж батлагдсан үнийг Захиргааны Хэм Хэмжээний Актын Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн мөрдөн ажиллахыг “Улаанбаатар төмөр зам” БЗАУАнгийн гүйцэтгэх захирал /Т.Батмөнх/-д үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2021 оны 10 дугаар сарын 28-ний өдрийн 16 тоот “Үнэ тариф батлах тухай” тогтоолыг хүчингүйд тооцсугай.

4.Хэрэглэгч, хангагчийн эрх ашгийг хангах үүднээс тогтоолын хэрэгжилтэнд байнгын хяналт тавьж ажиллахыг Төв аймгийн Эрчим Хүчний Зохицуулах Зөвлөл /Ц.Оюунчимэг /-д даалгасугай .

ДАРГА

Ц.ОЮУНЧИМЭГ

ГИШҮҮН

Ц.НЯМГАРАВ

*Төв аймгийн Эрчим хүчний зохицуулах
зөвлөлийн 2025 оны 07 дугаар сарын
07-ний өдрийн 18 дугаар тогтоолын хавсралт*

**“УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ” БЗАҮАНГИЙН ЭЗЭМШЛИЙН
ДУЛААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН “МАНДАЛ”
ӨРТӨӨНИЙ ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ
ХҮЧНИЙ ТАРИФ**

Төв аймгийн “Улаанбаатар төмөр зам” БЗАҮАнгийн эзэмшлийн дулаан түгээх шугам, сүлжээнд холбогдсон Батсүмбэр сумын “Мандал” өртөөний хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ)-гүй ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
1	Төсөвт байгууллагад борлуулах дулааны эрчим хүчний тариф	Төг/м3	2 200.0
2	Үйлдвэр, Аж Ахуйн Нэгж, байгууллагад борлуулах дулааны эрчим хүчний тариф	Төг/м3	1 500.0
3	Айл өрх болон Орон сууцанд борлуулах дулааны эрчим хүчний тариф	Төг/м2	800.0

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 7369 дүгээрт бүртгэв.

ТӨВ АЙМГИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 7 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 19

Зуунмод

ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3, 26 дугаар зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн Төв аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч “Улаанбаатар төмөр зам” БЗАУАнгийн эзэмшлийн дулаан түгээх шугам сүлжээнд холбогдсон Баян сумын “Мааньт” өртөөний албан байгууллага болон айл өрхөд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2.Халаалтын горимыг чанд баримтлан, хэрэглэгчдийг шаардлагатай дулаанаар хангаж батлагдсан үнийг Захиргааны Хэм Хэмжээний Актын Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн мөрдөн ажиллахыг “Улаанбаатар төмөр зам” БЗАУАнгийн гүйцэтгэх захирал /Т.Батмөнх/-д үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2021 оны 10 дугаар сарын 28-ний өдрийн 14 тоот “Үнэ тариф батлах тухай” тогтоолыг хүчингүйд тооцсугай.

4.Хэрэглэгч, хангагчийн эрх ашгийг хангах үүднээс тогтоолын хэрэгжилтэнд байнгын хяналт тавьж ажиллахыг Төв аймгийн Эрчим Хүчний Зохицуулах Зөвлөл /Ц.Оюунчимэг /-д даалгасугай .

ДАРГА

Ц.ОЮУНЧИМЭГ

ГИШҮҮН

Ц.НЯМГАРАВ

*Төв аймгийн Эрчим хүчний зохицуулах
зөвлөлийн 2025 оны 07 дугаар сарын
07-ний өдрийн 19 дүгээр тогтоолы хавсралт*

**“УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ” БЗАҮАНГИЙН ЭЗЭМШЛИЙН
ДУЛААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН “МААНЬТ”
ӨРТӨӨНИЙ ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ
ХҮЧНИЙ ТАРИФ**

Төв аймгийн “Улаанбаатар төмөр зам” БЗАҮАнгийн эзэмшлийн дулаан түгээх шугам, сүлжээнд холбогдсон Баян сумын “Мааньт” өртөөний хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ)-гүй ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
1	Төсөвт байгууллагад борлуулах дулааны эрчим хүчний тариф	Төг/м3	1 600.0
2	Айл өрх болон Орон сууцанд борлуулах дулааны эрчим хүчний тариф	Төг/м2	700.0

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 7370 дугаарт бүртгэв.

ТӨВ АЙМГИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 7 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 20

Зуунмод

ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3, 26 дугаар зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн Төв аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч “Улаанбаатар төмөр зам” БЗАҮАнгийн эзэмшлийн дулаан түгээх шугам сүлжээнд холбогдсон Архуст сумын “Булагтай” өртөөний албан байгууллага болон айл өрхөд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2.Халаалтын горимыг чанд баримтлан, хэрэглэгчдийг шаардлагатай дулаанаар хангаж батлагдсан үнийг Захиргааны Хэм Хэмжээний Актын Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн мөрдөн ажиллахыг “Улаанбаатар төмөр зам” БЗАҮАнгийн гүйцэтгэх захирал /Т.Батмөнх/-д үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2021 оны 10 дугаар сарын 28-ний өдрийн 15 тоот “Үнэ тариф батлах тухай” тогтоолыг хүчингүйд тооцсугай.

4.Хэрэглэгч, хангагчийн эрх ашгийг хангах үүднээс тогтоолын хэрэгжилтэнд байнгын хяналт тавьж ажиллахыг Төв аймгийн Эрчим Хүчний Зохицуулах Зөвлөл /Ц.Оюунчимэг /-д даалгасугай.

ДАРГА

Ц.ОЮУНЧИМЭГ

ГИШҮҮН

Ц.НЯМГАРАВ

*Төв аймгийн Эрчим хүчний зохицуулах
зөвлөлийн 2025 оны 07 дугаар сарын
07-ний өдрийн 20 дугаар тогтоолын хавсралт*

**“УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ” БЗАҮАНГИЙН ЭЗЭМШЛИЙН
ДУЛААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН “БУЛАГТАЙ”
ӨРТӨӨНИЙ ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ
ХҮЧНИЙ ТАРИФ**

Төв аймгийн “Улаанбаатар төмөр зам” БЗАҮАнгийн эзэмшлийн дулаан түгээх шугам, сүлжээнд холбогдсон Архуст сумын “Булагтай” өртөөний хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ)-гүй ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
1	Төсөвт байгууллагад борлуулах дулааны эрчим хүчний тариф	Төг/м3	2 200.0
2	Үйлдвэр, Аж Ахуйн Нэгж, байгууллагад борлуулах дулааны эрчим хүчний тариф	Төг/м3	1 500.0
3	Айл өрх болон Орон сууцанд борлуулах дулааны эрчим хүчний тариф	Төг/м2	800.0

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 7371 дүгээрт бүртгэв.

ТӨВ АЙМГИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 7 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 21

Зуунмод

ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3, 26 дугаар зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн Төв аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч “Төв чандмань ДЭХГ” ОНӨАТҮГ-ын эзэмшлийн дулаан түгээх шугам сүлжээнд холбогдсон Бүрэн сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2.Халаалтын горимыг чанд баримтлан, хэрэглэгчдийг шаардлагатай дулаанаар хангаж батлагдсан үнийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөн ажиллахыг “Төв чандмань ДЭХГ” ОНӨАТҮГ-ын гүйцэтгэх захирал /Д.Баярбат/-д үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2020 оны 07 дугаар сарын 22-ний өдрийн 13 тоот “Үнэ тариф батлах тухай” тогтоолыг хүчингүйд тооцсугай.

4.Хэрэглэгч, хангагчийн эрх ашгийг хангах үүднээс тогтоолын хэрэгжилтэнд байнгын хяналт тавьж ажиллахыг Төв аймгийн Эрчим Хүчний Зохицуулах Зөвлөл /Ц.Оюунчимэг /-д даалгасугай.

ДАРГА

Ц.ОЮУНЧИМЭГ

ГИШҮҮН

Ц.НЯМГАРАВ

*Төв аймгийн Эрчим хүчний зохицуулах
зөвлөлийн 2025 оны 07 дугаар сарын
07-ний өдрийн 21 дүгээр тогтоолын хавсралт*

**“ТӨВ ЧАНДМАНЬ ДЭХГ” ОНӨАТҮГ-ЫН ЭЗЭМШЛИЙН
ДУЛААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН БҮРЭН СУМЫН
ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

Төв аймгийн “Төв чандмань ДЭХГ” ОНӨАТҮГ-ын эзэмшлийн дулаан түгээх шугам, сүлжээнд холбогдсон Бүрэн сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ)-гүй ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
1	Төсөвт байгууллагад борлуулах дулааны эрчим хүчний тариф	Төг/м3	2200.0
2	Үйлдвэр, Аж Ахуйн Нэгж, байгууллагад борлуулах дулааны эрчим хүчний тариф	Төг/м3	1450.0
3	Айл өрх болон Орон сууцанд борлуулах дулааны эрчим хүчний тариф	Төг/м2	800.0

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 7372 дугаарт бүртгэв.

ТӨВ АЙМГИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 7 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 22

Зуунмод

ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3, 26 дугаар зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн Төв аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч “Винтер Гарден” ХХК-ний эзэмшлийн дулаан түгээх шугам сүлжээнд холбогдсон Баянчандмань сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2.Халаалтын горимыг чанд баримтлан, хэрэглэгчдийг шаардлагатай дулаанаар хангаж батлагдсан үнийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөн ажиллахыг “Винтер Гарден” ХХК-ний захирал /С.Сумъяацэцэг/-д үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 13-ний өдрийн 02 тоот “Үнэ тариф батлах тухай” тогтоолыг хүчингүйд тооцсугай.

4.Хэрэглэгч, хангагчийн эрх ашгийг хангах үүднээс тогтоолын хэрэгжилтэнд байнгын хяналт тавьж ажиллахыг Төв аймгийн Эрчим Хүчний Зохицуулах Зөвлөл /Ц.Оюунчимэг /-д даалгасугай.

ДАРГА

Ц.ОЮУНЧИМЭГ

ГИШҮҮН

Ц.НЯМГАРАВ

*Төв аймгийн Эрчим хүчний зохицуулах
зөвлөлийн 2025 оны 07 дугаар сарын
07-ний өдрийн 22 дугаар тогтоолын хавсралт*

**“ВИНТЕР ГАРДЕН” ХХК-НИЙ ЭЗЭМШЛИЙН ДУЛААН ТҮГЭЭХ
СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН БАЯНЧАНДМАНЬ СУМЫН
ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

Төв аймгийн “Винтер Гарден” ХХК-ний эзэмшлийн дулаан түгээх шугам, сүлжээнд холбогдсон Баянчандмань сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ)-гүй ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
1	Төсөвт байгууллагад борлуулах дулааны эрчим хүчний тариф	Төг/м3	2000.0
2	Үйлдвэр, Аж Ахуйн Нэгж, байгууллагад борлуулах дулааны эрчим хүчний тариф	Төг/м3	1250.0
3	Айл өрх болон Орон сууцанд борлуулах дулааны эрчим хүчний тариф	Төг/м2	880.0

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 7373 дугаарт бүртгэв.

ТӨВ АЙМГИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 7 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 23

Зуунмод

ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3, 26 дугаар зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн Төв аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч “Өвменежмент” ХХК-ний эзэмшлийн дулаан түгээх шугам сүлжээнд холбогдсон Баяндэлгэр сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2.Халаалтын горимыг чанд баримтлан, хэрэглэгчдийг шаардлагатай дулаанаар хангаж батлагдсан үнийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөн ажиллахыг “Өвменежмент” ХХК-ний захирал /С.Хишигдорж/-д үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөлийн “Үнэ тариф батлах тухай” 2022 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 24 тоот тогтоолыг хүчингүйд тооцсугай.

4.Хэрэглэгч, хангагчийн эрх ашгийг хангах үүднээс тогтоолын хэрэгжилтэнд байнгын хяналт тавьж ажиллахыг Төв аймгийн Эрчим Хүчний Зохицуулах Зөвлөл /Ц.Оюунчимэг /-д даалгасугай .

ДАРГА

Ц.ОЮУНЧИМЭГ

ГИШҮҮН

Ц.НЯМГАРАВ

*Төв аймгийн Эрчим хүчний зохицуулах
зөвлөлийн 2025 оны 07 дугаар сарын
07-ний өдрийн 23 дугаар тогтоолын хавсралт*

**“ӨВМЕНЕЖМЕНТ” ХХК-НИЙ ЭЗЭМШЛИЙН ДУЛААН
ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН БАЯНДЭЛГЭР СУМЫН
ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

Төв аймгийн “Өвменежмент” ХХК-ний эзэмшлийн дулаан түгээх шугам, сүлжээнд холбогдсон Баяндэлгэр сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ)-гүй ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
1	Төсөвт байгууллагад борлуулах дулааны эрчим хүчний тариф	Төг/м3	2245.0
2	Үйлдвэр, Аж Ахуйн Нэгж, байгууллагад борлуулах дулааны эрчим хүчний тариф	Төг/м3	1250.0
3	Айл өрх болон Орон сууцанд борлуулах дулааны эрчим хүчний тариф	Төг/м2	880.0

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 7374 дүгээрт бүртгэв.

ТӨВ АЙМГИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 7 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 24

Зуунмод

ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3, 26 дугаар зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн Төв аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч “Өвменежмент” ХХК-ний эзэмшлийн дулаан түгээх шугам сүлжээнд холбогдсон Мөнгөнморьт сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2.Халаалтын горимыг чанд баримтлан, хэрэглэгчдийг шаардлагатай дулаанаар хангаж батлагдсан үнийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөн ажиллахыг “Өвменежмент” ХХК-ний захирал /С.Хишигдорж/-д үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөлийн “Үнэ тариф батлах тухай” 2022 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 23 тоот тогтоолыг хүчингүйд тооцсугай.

4.Хэрэглэгч, хангагчийн эрх ашгийг хангах үүднээс тогтоолын хэрэгжилтэнд байнгын хяналт тавьж ажиллахыг Төв аймгийн Эрчим Хүчний Зохицуулах Зөвлөл /Ц.Оюунчимэг /-д даалгасугай.

ДАРГА

Ц.ОЮУНЧИМЭГ

ГИШҮҮН

Ц.НЯМГАРАВ

*Төв аймгийн Эрчим хүчний зохицуулах
зөвлөлийн 2025 оны 07 дугаар сарын
07-ний өдрийн 24 дүгээр тогтоолын хавсралт*

**“ӨВМЕНЕЖМЕНТ” ХХК-НИЙ ЭЗЭМШЛИЙН ДУЛААН ТҮГЭЭХ
СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН МӨНГӨНМОРЬТ СУМЫН
ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

Төв аймгийн “Өвменежмент” ХХК-ний эзэмшлийн дулаан түгээх шугам, сүлжээнд холбогдсон Мөнгөнморьт сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ)-гүй ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
1	Төсөвт байгууллагад борлуулах дулааны эрчим хүчний тариф	Төг/м3	2248.0
2	Үйлдвэр, Аж Ахуйн Нэгж, байгууллагад борлуулах дулааны эрчим хүчний тариф	Төг/м3	1250.0
3	Айл өрх болон Орон сууцанд борлуулах дулааны эрчим хүчний тариф	Төг/м2	880.0

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 7375 дугаарт бүртгэв.

ТӨВ АЙМГИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 7 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 25

Зуунмод

ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3, 26 дугаар зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн Төв аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч “Бат комплект” ХХК-ний эзэмшлийн дулаан түгээх шугам сүлжээнд холбогдсон Архуст сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2.Халаалтын горимыг чанд баримтлан, хэрэглэгчдийг шаардлагатай дулаанаар хангаж батлагдсан үнийг “Улсын нэгдсэн санд” бүртгэгдсэн өдрөөс эхлэн мөрдөн ажиллахыг “Бат комплект” ХХК-ний захирал /Х.Цэрэнбат/-д үүрэг болгосугай.

3.Хэрэглэгч, хангагчийн эрх ашгийг хангах үүднээс тогтоолын хэрэгжилтэнд байнгын хяналт тавьж ажиллахыг Төв аймгийн Эрчим Хүчний Зохицуулах Зөвлөл /Ц.Оюунчимэг /-д даалгасугай .

ДАРГА

Ц.ОЮУНЧИМЭГ

ГИШҮҮН

Ц.НЯМГАРАВ

*Төв аймгийн Эрчим хүчний зохицуулах
зөвлөлийн 2025 оны 07 дугаар сарын
28-ний өдрийн 25 дугаар тогтоолын хавсралт*

**“БАТ КОМПЛЕКТ” ХХК-НИЙ ЭЗЭМШЛИЙН ДУЛААН ТҮГЭЭХ
СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН АРХУСТ СУМЫН ХЭРЭГЛЭГЧДЭД
БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

“Бат комплект” ХХК-ний эзэмшлийн дулаан түгээх шугам, сүлжээнд холбогдсон Архуст сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ)-гүй ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
1	Төсөвт байгууллагад борлуулах дулааны эрчим хүчний тариф	Төг/м3	2400.0
2	Үйлдвэр, Аж Ахуйн Нэгж, байгууллагад борлуулах дулааны эрчим хүчний тариф	Төг/м3	1350.0

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 7376 дугаарт бүртгэв.

ХЭНТИЙ АЙМГИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 9 дүгээр
сарын 11-ний өдөр

Дугаар 14

Чингис хот

ТАРИФ ТОГТООХ ТУХАЙ

Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Хэнтий аймгийн зохицуулах зөвлөлөөс ТОГТООХ нь:

Нэг.Хэнтий аймгийн хэмжээнд дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах Тусгай зөвшөөрөл эзэмшигч “Цагаан цахир уул” ХХК, “Суно” ХХК, “Нямодо трейд”ХХК, “Хурх илч”ХХК,“Их баян бүрд” ХХК, “Жизи номадс” ХХК, “Хангай илч” ХХК-ны Баян Овоо сумын хэрэглэгчдэд худалдан борлуулах халаалтын үнийг хавсралтаар тогтоож мөрдсүгэй.

Хоёр.Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын мөрдөж байгаа 2023 оны 09-р сарын 28 ний 07 тогтоол, 2023 оны 12-р сарын 19-ний өдрийн 10-р тогтоол, 2023 оны 12-р сарын 20-ний өдрийн 13-р тогтоол, 2023 оны 12-р сарын 20-ний өдрийн 26-р дугаартай үнэ тарифын тогтоолуудыг тус тус хүчингүйд тооцсугай.

Гурав.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны бус гишүүн /Т.ЖАНЧИВ/-т даалгасугай.

ДАРГА

Г. БАТГЭРЭЛ

ОРОН ТООНЫ БУС ГИШҮҮН
ОРОН ТООНЫ БУС ГИШҮҮН

Т.ЖАНЧИВ
Н. ҮНЭНБАТ

Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн
2025 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн
14 дүгээр тогтоолын хавсралт

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллага	Үйл ажиллагаа явуулж буй сум	Хэмжих нэгж	Төсөвт байгууллага		Аж ахуйн нэгж байгууллага		Айл өрх	
				/нөөт/-гүй	/нөөт/-тай	/нөөт/-гүй	/нөөт/-тай	/нөөт/-гүй	/нөөт/-тай
1	Цагаан цахир уул ХХК	Хэрлэн	м³	1980	2178	1980	2178	1000	1100
2	Суно ХХК	Хэрлэн	м³	1900	2090	1900	2090	1000	1100
3	Нямодо трейд ХХК	Хэрлэн	м³	1900	2090	1900	2090	1000	1100
4	Хурх илч ХХК	Гурван баян	м³	1920	2112	1920	2112	1000	1100
5	Их баян бүрд ХХК	Хэрлэн сум	м³	1900	2090	1900	2090	1000	1100
6	Жизи номадс ХХК	Тахилгат тосгон	м³	1900	2090	1900	2090	1000	1100
7	Хангай илч ХХК	Баян-Овоо	м³	2000	2200	2000	2200	1000	1100

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 7377 дугаарт бүртгэв

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН ТУШААЛ

2025 оны 10 дугаар
сарын 01-ний өдөр

Дугаар А/253

Улаанбаатар
хот

ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГЫГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9, 22.11 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Албан татвар төлөгчийн орлого олох үйл ажиллагаатай хамааралгүй аж ахуйн нэгжийн нийгмийн хариуцлагын хүрээнд агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг хавсралтаар баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг холбогдох газрын дарга нарт, тавигдах шаардлагыг аж ахуйн нэгж, иргэдэд сурталчлан таниулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого, төлөвлөлийн газар (Б.Ерэн-Өлзий)-д даалгасугай.

3.Албан татварын хөнгөлөлтөд хамрагдсан аж ахуйн нэгж нь шаардлага, стандартыг хангаагүй нь тогтоогдсон тохиолдолд энэ талаар тухай бүр татварын албанд мэдэгдэх болон хөнгөлөлтөд хамрагдсан бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагааны статистик мэдээллийг нэгтгэн хагас жил тутам тайлагнаж ажиллахыг Санхүү хөрөнгө, оруулалтын газар (О.Хуягцогт)-д, тушаалын хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж ажиллахыг Хяналт, шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын газар (Х.Бекболат)-д тус тус үүрэг болгосугай.

4.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний сайдын 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/117 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Б.ЧОЙЖИЛСҮРЭН

*Эрчим хүчний сайдын 2025 оны 10 дугаар сарын 01-ний
өдрийн А/253 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт*

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ ЭДЛЭХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ТӨСӨЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ НИЙТЛЭГ ШААРДЛАГА

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9.1-д заасан ой, амьтан, ус зэрэг байгалийн баялаг хамгаалах, нөөцийг нэмэгдүүлэх, зохистой ашиглах, нөхөн сэргээх, агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах, цөлжилтийг сааруулах чиглэлээр хэрэгжүүлсэн татварын хөнгөлөлтөд хамрагдах бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага, стандартыг тодорхойлох, түүнд хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд энэхүү шаардлагыг баримтална.

1.2.Албан татварын хөнгөлөлт эдлүүлэхдээ Татварын ерөнхий хуулийн хугацааг баримтална.

Хоёр.Эрчим хүчний салбарын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлага

2.1.Татварын хөнгөлөлтөд хамрагдах бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд оруулсан хөрөнгө оруулалт нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.1.1.татвар төлөгчийн нийгмийн хариуцлагын хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрийн, эсхүл өөр хуулийн этгээдийн элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан бодитой хөрөнгө оруулалт байх;

2.1.2.татвар төлөгчийн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 8.1, 8.5-д заасан үндсэн үйл ажиллагаатай хамааралгүй байх;

2.1.3.татвар төлөгчийн өөрийн хэрэгжүүлэх бүтээн байгуулалт, төслийн хувьд тухайн татвар төлөгчийн удирдах дээд байгууллагын баталсан бизнесийн төлөвлөгөөнд туссан, санхүүгийн тайланд элэгдэл тооцох үндсэн хөрөнгөөр бүртгэгдсэн байх;

2.1.4.татвар төлөгч бусад этгээдэд хөрөнгө оруулалт хийх тохиолдолд тухайн этгээдтэй төсөл, үйл ажиллагаанд нь хөрөнгө оруулалт хийх гэрээ байгуулж, гэрээг нотариатаар гэрчлүүлэн, хөрөнгө оруулалт авч буй талын санхүүгийн тайланд элэгдэл тооцох үндсэн хөрөнгөөр бүртгэгдсэн байх.

2.2.Татварын хөнгөлөлтөд хамрагдах бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд үзүүлсэн санхүүгийн дэмжлэг, хандив нь дараах

шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.2.1.хариу төлбөргүй шилжүүлсэн мөнгөн болон биет хөрөнгө байх;

2.2.2.санхүүгийн дэмжлэг, хандив хүлээн авч буй этгээд нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хандив олгох татвар төлөгчтэй харилцан хамааралгүй байх;

2.2.3.Иргэний хуулийн 195 дугаар зүйлд заасныг баримтлан санхүүгийн дэмжлэг, хандивын тусгай зориулалтыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9-д нийцүүлэн тусгасан гэрээ байгуулж, гэрээг нотариатаар гэрчлүүлсэн байх;

2.2.4.санхүүгийн дэмжлэг, хандив олгосон болон хүлээн авсан этгээд нь тухайн санхүүгийн дэмжлэг, хандивыг энэхүү шаардлага, стандартын 2.2.3-т заасан гэрээнд тусгасан зориулалтын дагуу тухайн тайлант хугацаанд зарцуулсан гэдгийг хүлээн зөвшөөрч, гэрээг цуцлах болон татгалзахгүй тухайгаа илэрхийлсэн акт үйлдэж, нотариатаар гэрчлүүлсэн байх;

2.2.5.санхүүгийн дэмжлэг, хандивын зардал нь Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтаар баталгаажсан байх.

2.3.Энэхүү шаардлагын 2.1, 2.2-т заасан хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандив нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13.1.1, 13.1.3, 13.1.4. 13.1.5-д заасан хасагдах зардлын шаардлагыг хангасан байна.

2.4.Бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаа нь хоёрдугаар хавсралтад заасан шаардлага, стандартыг хангасан байна.

Гурав.Албан татварын хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаа

3.1.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9.1-т заасан ой, амьтан, ус зэрэг байгалийн баялаг хамгаалах, нөөцийг нэмэгдүүлэх, зохистой ашиглах, нөхөн сэргээх, агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах, цөлжилтийг сааруулах чиглэлээр төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Дөрөв.Бусад

4.1.Аж ахуйн нэгж нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9 дэх хэсгийг татвараас зайлсхийх үндсэн зорилгоор ашигласан тохиолдолд татварын холбогдох хуульд заасны дагуу хөнгөлөлт эдлүүлэх үндэслэл болохгүй.

4.2.Аж ахуйн нэгжийн оруулсан хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандив нь нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулагдаагүй, гэрээний хэрэгжилт хангагдаагүй нь тогтоогдсон тохиолдолд татварын холбогдох хуульд заасны дагуу хөнгөлөлт эдлүүлэх үндэслэл болохгүй.

4.3.Албан татварын хөнгөлөлтөд тодорхойлохдоо Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 20.1, 22.9 дэх хэсгийг тус тус дагаж мөрдөнө.

Эрчим хүчний сайдын 2025 оны
10 дугаар сарын 01-ний өдрийн А/253
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ ЭДЛЭХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ,
ТӨСӨЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

№	Татварын хөнгөлөлт олгох чиглэл	Зорилго, үндэслэл	Стандарт, журам	Нийтлэг тавигдах шаардлага	Тусгай шаардлага	Тайлбар
Агаар						
1	Дэвшилтэт техник, технологич бүхий хийн зуух	Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор хийн түлшийг ашиглаж дулааны эрчим хүч үйлдвэрлэж хэрэглэгчдийг хангах;	MNS 5043:2016 Техникийн ерөнхий шаардлага хангасан байх;	Төрийн захиргааны төв байгууллага болон нутгийн захиргааны төв байгууллагатай хамтран баталсан агаарын чанарыг сайжруулах бүсэд хамаарсан байх;	4.2 МВт хүртэл хүчин чадалтай хийн зуухны техникийн тодорхойлолт, үйлдвэрлэгчийн гэрчилгээтэй байх; Сум, дүүргийн ЗДТГ-тай гэрээ байгуулж, хүлээлгэн өгсөн байх;	Хийн зуух нь нефтийн шингэрүүлсэн хий болон байгалийн хийгээр ажиллаж тухайн барилга байгууламжийг дулааны эрчим хүчээр хангах зориулалттай байна.

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 9 дүгээр
сарын 23-ны өдөр

Дугаар А/236

Улаанбаатар
хот

ДҮРЭМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Агаарын зайг тогтоох, ангилах болон агаарын зайн зохицуулалт хийх үйл ажиллагааг зохицуулах Иргэний нисэхийн дүрэм “ИНД-71 Агаарын зайг тогтоох, ангилах”-ыг нэгдүгээр хавсралтаар, “ИНД-77 Нислэг үйлдэх агаарын зайд нөлөөлөх байгууламж, үйл ажиллагаа”-г хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Иргэний нисэхийн дүрмийг мөрдөж, дүрмийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн шаардлагатай тохиолдолд боловсронгуй болгох ажлыг зохион байгуулж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газар (Э.Төрбаяр), энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэний нисэхийн бодлого зохицуулалтын газар (З.Туяа)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны “Багц дүрэм батлах тухай” 187 дугаар тушаалын 11 дүгээр хавсралтаар баталсан Иргэний нисэхийн багц дүрэм-11 “Монгол Улсын агаарын зайн хориотой бүсэд нислэг үйлдэх”-ийн “ИНД-71 Агаарын зайг тогтоох болон ангилах”, “ИНД-77 Нислэг үйлдэх агаарын зайд нөлөөлөх байгууламж” дүрмийг тус тус бүхэлд нь хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

*Зам, тээврийн сайдын 2025 оны 9 дүгээр сарын 23-ны
өдрийн А/236 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт*

ИНД-71 Агаарын зайг тогтоох, ангилах

А Бүлэг - Ерөнхий зүйл

71.1. Зорилго

(а) Энэ дүрмээр дараах харилцааг зохицуулна:

(1) Монгол Улсын хилийн шугамаас дотогш агаарын зайг тогтоох, ангилахад тавигдах шаардлага;

(2) олон улсын иргэний нисэхийн гэрээгээр Монгол Улс хариуцахаар хүлээн зөвшөөрсөн агаарын зайг тогтоох, ангилахад тавигдах шаардлага.

71.2. Нэр томьёо болон товчлол

(а) Энэ дүрэмд хэрэглэсэн нэр томьёо болон товчлолыг ИНД-1 Нэр томьёоны тайлбарт тусгасан.

71.3. Агаарын зайг тогтоох, ангилах шаардлага

(а) Энэ дүрмийн дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга бөгөөд иргэний нисэхийн хяналтын улсын ерөнхий байцаагч (цаашид “Дарга” гэх) нь:

(1) Монгол Улсын Нислэгийн мэдээллийн бүс (цаашид “FIR” гэх) доторх агаарын зайн аливаа хэсгийг дараах нэг, эсхүл хэд хэдэн хэлбэрээр тогтоож болно:

(i) хэрэв Дарга тухайн FIR дотор үзүүлэх Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ (цаашид “НХҮ” гэх)-ний аюулгүй, үр ашигтай болон дэс дараалсан байдлыг хангах зорилгоор тогтоох шаардлагатай гэж үзвэл сектороор;

(ii) В Бүлгийн дагуу хяналттай болон холбогдох агаарын зайгаар;

(iii) D Бүлгийн дагуу тусгай зориулалтаар ашиглах агаарын зайгаар;

(iv) E Бүлгийн дагуу транспондер шаардлагатай агаарын зайгаар;

(2) F Бүлгийн дагуу ил харааны илтгэх цэг, бүсийн Газарт тухайн өндөрлөгийг тодорхойлох зорилгоор алтиметрийн даралтын цонхны заалтыг тохируулах (цаашид “QNH” гэх) зон, уулархаг зон болон бусад хэлбэрээр тогтоож болно.

(b) С Бүлгийн дагуу Дарга энэ зүйлийн (а)(1)(ii)-ын дагуу хяналттай агаарын зайгаар тогтоосон агаарын зайг ангилна.

(c) С Бүлгийн дагуу Дарга энэ зүйлийн (а)(1)(ii)-ын дагуу хяналттай агаарын зайгаар тогтоогдоогүй агаарын зайн хэсгийг F ангиллаар ангилж болно.

(d) Энэ зүйлийн (а)(1)(ii)-ын дагуу хяналттай агаарын зайгаар

тогтоогоогүй FIR доторх агаарын зайн аливаа хэсгийг энэ зүйлийн (с) хэсгийн дагуу F ангиллын агаарын зайгаар ангилаагүй тохиолдолд хяналтгүй агаарын зай бөгөөд G ангиллаар ангилна.

71.5. Тогтоосон агаарын зайн хил, хязгаар

(а) Энэ дүрмийн дагуу тогтоосон агаарын зайн хажуугийн хэвтээ хязгаарыг дараах байдлаар тодорхойлно:

- (1) хэм, минут, секундээр илэрхийлсэн газар зүйн солбицлоор;
- (2) дараах нэг, эсхүл хэд хэдэн дүрслэлээр:
 - (i) газар зүйн танигдахуйц онцлог шинж тэмдгээр;
 - (ii) газар зүйн солбицолд төвтэй радиусаар тогтоосон тойрог, эсхүл түүний аливаа хэсгээр;
 - (iii) хоёр цэгийг холбосон их тойргийн шугамаар;
 - (iv) өргөрөгтэй параллель шугамаар.

(b) Энэ дүрмийн дагуу тогтоосон агаарын зайн босоо хязгаарыг өндөр, түвшин, эсхүл нислэгийн түвшнээр тодорхойлох ёстой.

(c) Хэрэв өөрөөр тогтоогоогүй бол тухайн өндрийн ойлголтод түүний өндөр багтана.

71.7. Агаарын зайг тогтоох, ангилах хүсэлт гаргах

(а) Тухайн агаарын зайг зохих ёсоор нь ашиглах сонирхолтой этгээд энэ дүрмийн дагуу агаарын зайг тогтоох, эсхүл ангилах хүсэлтийг Даргад гаргаж болно.

(b) Агаарын зайг тогтоох, эсхүл ангилах хүсэлт гаргагч нь дараах дэлгэрэнгүй мэдээллийг Даргад хүргүүлэх үүрэгтэй:

- (1) хүсэлт гаргагчийн нэр болон холбоо барих дэлгэрэнгүй мэдээлэл;
- (2) тогтоох, эсхүл ангилах шаардлагатай төрөл;
- (3) тогтоох, эсхүл ангилах шалтгаан;
- (4) шаардлагатай агаарын зайн хэмжээ, эсхүл хил хязгаарын бусад мэдээлэл;
- (5) тогтоох, эсхүл ангилах шаардлагатай хугацаа;
- (6) хариуцсан эрх бүхий байгууллага, эсхүл хэрэглэгч байгууллагын холбоо барих дэлгэрэнгүй мэдээлэл;
- (7) Даргын шаардсан бусад холбогдох мэдээлэл.

(c) Эрэн хайх, авран туслах үйл ажиллагаа болон үндэсний аюулгүй байдал, эсхүл бусад онцгой нөхцөл, байдалтай холбоотой хүсэлтээс бусад агаарын зайг тогтоох, эсхүл ангилах хүсэлтийг тухайн агаарын зайг тогтоосон, эсхүл ангилсан хугацаа хүчинтэй болох өдрөөс 90-ээс доошгүй хоногийн өмнө Даргад хүргүүлсэн байх үүрэгтэй.

71.9. Агаарын зайг тогтоох, ангилах журам

(а) Энэ дүрмийн дагуу агаарын зайг тогтоох, эсхүл ангилахаас өмнө Дарга дараах агаарын зайн шаардлагатай холбогдуулан тухайн

тохиолдол бүрд хамааралтай гэж үзсэн нисэхийн болон бусад салбар дахь хувь хүн, байгууллага, төлөөллийн бүлэг, мөн яам, агентлагтай зөвлөлдсөн байна:

- (1) В Бүлэг (хяналттай агаарын зай);
- (2) С Бүлэг (агаарын зайн ангилал);
- (3) D Бүлэг (тусгай зориулалтаар ашиглах агаарын зай);
- (4) E Бүлэг (транспондер шаардлагатай агаарын зай);
- (5) F Бүлэг (илтгэх цэг, бүсийн QNH зон, уулархаг зон болон

өөр бусад тогтоолт).

(b) Энэ дүрмийн дагуу тогтоосон, эсхүл ангилсан агаарын зайд Дарга дараах хүчин зүйлийг тогтооно:

(1) тогтоосон, эсхүл ангилсан агаарын зайн идэвхтэй байх хугацаа, эсхүл

(2) тогтоосон, эсхүл ангилсан агаарын зайг идэвхтэй болгох арга.

(c) Энэ дүрмийн дагуу тогтоосон болон ангилсан илтгэх цэг, бүсийн QNH зон, уулархаг зоны агаарын зай нь энэ зүйлийн (d) болон (e) хэсгийн дагуу тэдгээр агаарын зайг мэдэгдэх, хэвлэн нийтлэх хүртэл хүчинтэй болохгүй.

(d) Энэ зүйлийн (g) хэсэгт зааснаас бусад тохиолдолд Дарга дараах мэдээллийг www.mcaa.gov.mn цахим хуудсаар мэдэгдсэн болохыг бататгана:

- (1) тогтоосон агаарын зай;
- (2) агаарын зайн ангилал;
- (3) тогтоосон илтгэх цэг;
- (4) тогтоосон бүсийн QNH зон;
- (5) тогтоосон уулархаг зон.

(e) Дарга тогтоосон, эсхүл ангилсан агаарын зайн мэдээлэл болон тогтоосон илтгэх цэг, бүсийн QNH зон болон уулархаг зоны дэлгэрэнгүй мэдээллийг дараах хэлбэрээр мэдээлсэн болохыг бататгана:

(1) Нисэхийн мэдээллийн эмхэтгэл (цаашид “AIP” гэх)-ийн нэмэлт хавсралт, эсхүл NOTAM-д хэвлэн нийтлэх;

(2) Монгол Улсын Агаарын навигацийн бүртгэл (цаашид “ANR” гэх)-д оруулах.

(f) Энэ зүйлийн (d) хэсгийн дагуу шаардсан www.mcaa.gov.mn цахим хуудсанд тавих мэдээлэлд тогтоосон, эсхүл ангилсан агаарын зайн хүчинтэй болох хугацааг заасан байна.

(g) Тогтоосон ба ангилсан агаарын зайн хүчинтэй хугацаа нь 6 сараас ихгүй хугацаанд хүчинтэй байх бол www.mcaa.gov.mn цахим хуудсаар зарлан мэдээлэх шаардлагагүй.

71.11. Тогтоосон, ангилсан агаарын зайд дүгнэлт хийх

(а) Дарга тогтоосон, эсхүл ангилсан агаарын зайн байнгын хэрэгцээг бататгахын тулд тогтоосон, эсхүл ангилсан агаарын зайг 5 жилээс хэтрэхгүй хугацаанд дахин хянаж, дүгнэлт хийнэ.

71.13. Тогтоосон агаарын зайг хүчингүй болгох, агаарын зайн ангиллыг өөрчлөх

(а) Хэрэв Дарга энэ дүрмийн дагуу тогтоосон эсхүл, ангилсан агаарын зайг цаашид шаардлагагүй, эсхүл тохиорохгүй гэж үзвэл, тогтоосон агаарын зайг хүчингүй болгож, эсхүл агаарын зайн ангиллыг өөрчилж болно.

(b) Энэ зүйлийн (d) хэсэгт зааснаас бусад тохиолдолд энэ зүйлийн (а) хэсгийн дагуу тогтоосон агаарын зайг хүчингүй болгох, эсхүл агаарын зайн ангиллын өөрчлөлт нь дараах ажиллагааг хийх хүртэл хүчинтэй болохгүй:

(1) хүчингүй болгосон, эсхүл өөрчилсөн тухай мэдээллийг www.mcaa.gov.mn цахим хуудсаар мэдээлэх;

(2) дэлгэрэнгүй мэдээллийг AIP-ийн нэмэлт хавсралт, эсхүл NOTAM-д хэвлэн нийтлэх;

(3) Монгол Улсын ANR-ийн дэлгэрэнгүй мэдээлэлд нэмэлт өөрчлөлт оруулах.

(c) Энэ зүйлийн (b)(1)-д шаардсан www.mcaa.gov.mn цахим хуудсанд тавих мэдээлэлд тогтоосон агаарын зайг хүчингүй болгох, эсхүл агаарын зайн ангиллын өөрчлөлт хүчинтэй болох өдрийг заасан байна.

(d) Энэ зүйлийн (b)(1) нь 6 сараас ихгүй хугацаагаар хүчинтэй байх, тогтоосон агаарын зай, эсхүл агаарын зайн ангилалд хамаарахгүй.

71.15. Монгол Улсын ANR

(а) Дарга Монгол Улсын ANR-ыг тогтоож, хөтөлнө.

(b) Дарга ANR нь дараах мэдээллийг агуулсан болохыг бататгана.

(1) энэ дүрмийн дагуу тогтоосон агаарын зайн хэсгүүдийн хүчинтэй тодорхойлолт;

(2) энэ дүрмийн дагуу F ангиллын агаарын зайгаар ангилсан агаарын зайн хэсгүүдийн хил хязгаарын мэдээллийн хүчинтэй тодорхойлолт;

(3) энэ дүрмийн дагуу тогтоосон ил харааны илтгэх цэгүүдийн нэр, эсхүл оноосон нэр болон солбицлыг багтаасан хүчинтэй мэдээлэл;

(4) “ИНД-95 Хэрэглэлийн нислэгийн журмын бүртгэл” дүрэмд шаардсан хүчинтэй Хэрэглэлийн нислэгийн журмын дэлгэрэнгүй мэдээлэл;

(5) баруун гарын аэродромын нислэгийн хөдөлгөөний хайрцгийн дэлгэрэнгүй мэдээлэл.

В Бүлэг - Хяналттай агаарын зай

71.51. Ерөнхий зүйл

(а) Хэрэв FIR доторх агаарын зайн хэсэгт Нислэгийн хөдөлгөөний удирдлага (цаашид “НХУ” гэх)-ын үйлчилгээ шаардлагатай болохыг тогтоосон бол Дарга дараах үүрэгтэй:

(1) агаарын зайн тухайн хэсгийг энэ Бүлгийн дагуу удирдлагын бүс, эсхүл удирдлагын зоноор тогтоох;

(2) агаарын зайн тухайн хэсгийг С Бүлгийн дагуу А, В, С, D, эсхүл E ангиллын агаарын зайгаар ангилах.

(b) Нөөц

(c) Дарга нислэгийн хөдөлгөөний зохицуулалтын аюулгүй, үр ашигтай болон дэс дараалсан байдлыг хангах зорилгоор удирдлагын бүсэд, эсхүл удирдлагын зонд агаарын зайн хэсгийг тодорхой сектороор тогтоож болно.

(d) Тухайн удирдлагын бүс, эсхүл удирдлагын зонд НХУ-ын үйлчилгээ үзүүлдэггүй цаг хугацаанд тухайн удирдлагын бүс, эсхүл удирдлагын зон нь G ангиллын хяналтгүй агаарын зай болно.

(e) Удирдлагын бүс, эсхүл удирдлагын зоноор тогтоосон агаарын зайн хэсгүүдийн хувьд Дарга дараах үүрэгтэй:

(1) тухайн удирдлагын бүс, эсхүл удирдлагын зонд НХУ-ын үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээсэн НХУ-ын нэгжийг тогтоох;

(2) удирдлагын бүс, эсхүл удирдлагын зоныг дараах байдлаар тэмдэглэх:

(i) НХУ-ын үйлчилгээ үзүүлж байгаа улсад Олон улсын иргэний нисэхийн байгууллага (цаашид “ICAO” гэх)-аас олгосон үндэсний харьяаллын үсгэн кодын араас «А» үсэг болон тоо дагалдуулах;

(ii) удирдлагын бүс, эсхүл удирдлагын зонд НХУ-ын үйлчилгээ үзүүлж байгаа НХУ-ын нэгжийн нэрээр; дээгүүр нь тогтоосон аэродром, хот, суурин, эсхүл газар зүйн онцлог шинж тэмдгийн нэрээр удирдлагын бүс, эсхүл удирдлагын зоныг таньж тогтоож болдог байхаас бусад тохиолдолд.

71.53. Удирдлагын бүс

(а) Дарга энэ дүрмийн дагуу тогтоосон удирдлагын бүсийг дараах хэлбэрээр тогтоож болно:

(1) хэрэв Дарга нэг, эсхүл хэд хэдэн томоохон аэродромын ойролцоох НХУ-ний нислэгийн замын уулзварт ойртолтын удирдлагын үйлчилгээ шаардлагатай болохыг тогтоосон бол Ойртолтын удирдлагын бүс (Terminal control area); эсхүл

(2) хэрэв Дарга бүсийн удирдлагын үйлчилгээ шаардлагатай болохыг тогтоосон бол Удирдлагын дээд бүс (Upper control area).

(b) Удирдлагын бүсийн дээд хязгаар нь 20,000 м (FL 660)-ийн нислэгийн түвшнээс хэтрэхгүй байх ёстой.

(c) Удирдлагын бүсийн доод хязгаар нь:

(1) Дарга Хэрэглэлийн нислэгийн дүрмийн дагуу үйлдэж байгаа нислэг (цаашид “IFR нислэг” гэх)-т НХУ-ын үйлчилгээ шаардлагатай гэж тогтоосон нислэгийн замаас доош 150 м (500 ft)-ээс багагүй өндөрт байх ёстой;

(2) дараах түвшинд тогтоогдсон байх ёстой:

(i) хамгийн их боломжит түвшинд;

(ii) газрын гадаргуугаас дээш 210 м (700 ft)-ээс багагүй өндөрт;

(3) удирдлагын бүсийн доод хязгаар нь Далайн дундаж түвшнээс дээш (цаашид “AMSL” гэх) 900 м (3,000 ft)-ээс дээш байгаа бол ИНД-91 [Нислэгийн үйл ажиллагааны ерөнхий дүрэм](#) (цаашид “ИНД-91” гэх)-д заасан Ил харааны нислэгийн дүрмийн дагуу үйлдэж байгаа нислэг (цаашид “VFR нислэг” гэх)-ийн аяллын түвшин, эсхүл нислэгийн түвшинтэй давхцах ёстой.

(d) Хэрэв удирдлагын бүсийн доод агаарын зайн хэсгийг өөр бусад удирдлагын бүсээр тогтоосон бол доод удирдлагын бүсийн дээд хязгаар нь түүний чанх дээр байгаа удирдлагын бүсийн доод хязгаар хүртэл үргэлжлэх ёстой.

71.55. Удирдлагын зон

(a) Дарга аэродром орчмын агаарын зайн тухайн хэсгийг дараах тохиолдолд удирдлагын зоноор тогтоож болно, хэрэв:

(1) Дарга аэродромын удирдлагын үйлчилгээ, эсхүл аэродром болон ойртолтын удирдлагын үйлчилгээ шаардлагатай болохыг тодорхойлсон бол;

(2) хөдөлгөөний нягтрал болон бүтэц нь хяналттай агаарын зай байхыг шаардсан бол.

(b) Удирдлагын зон нь тухайн аэродромд IFR нислэг нисэн ирэх болон нисэн гарах нислэгийн замыг бүрэн хамарч хамгаалах шаардлагад нийцсэн, аль болох бага хэмжээтэй байх ёстой.

(c) Удирдлагын зоны хажуугийн хэвтээ хязгаар нь:

(1) тухайн аэродромд Хэрэглэлийн нислэгийн цаг уурын нөхцөл (IMC)-д нисэн ирэх ба нисэн гарах IFR нислэгийн замыг багтаасан удирдлагын бүсэд багтдаггүй тэдгээр агаарын зайг хамарсан байх ёстой;

(2) тухайн аэродромын төвөөс хэрэглэлээр ойртолт үйлдэж болох чиглэлд 10 км-ээс (5 NM) багагүй зайд үргэлжилсэн байх ёстой;

(3) тухайн аэродромд агаарын хөлөг хэрэглэдэг IFR-ийн категори болон IFR-ийн нислэгийг хамгаалах шаардлагатай агаарын бүсийг тооцох ёстой.

(d) Удирдлагын зоны хажуугийн хэвтээ хязгаарыг тогтоохдоо боломжтой бол газарзүйн танигдахуйц онцлог шинж тэмдгийг ашиглах ёстой.

(e) Удирдлагын зоны дээд хязгаар нь AMSL 900 м (3,000 ft)-ээс дээш бол ИНД-91-д заасан VFR-ийн аяллын түвшин, эсхүл нислэгийн түвшинтэй давхцах ёстой.

71.57. VFR-ийн дамжин өнгөрөх зам

(a) Дарга дараах зорилгоор хяналттай агаарын зайн хэсгийг VFR нислэгийн дамжин өнгөрөх замаар тогтоож болно:

(1) дамжин өнгөрч байгаа VFR нислэгийн хөдөлгөөнийг нисэн ирэх болон нисэн гарах IFR нислэгээс тусгаарлах;

(2) НХУ-ын зөвшөөрөл шаардахгүйгээр VFR нислэгийн хөдөлгөөнийг VFR нислэгийн дамжин өнгөрөх замаар нэвтрэхийг зөвшөөрөх.

(b) VFR нислэг дамжин өнгөрөх зам нь хяналттай агаарын зайд IFR нислэгийн нисэн ирэх ба нисэн гарах агаарын зайнаас тусдаа байх ёстой.

(c) Дарга дараах үүрэгтэй:

(1) IFR нислэг нисэн ирэх, нисэн гарах хэвийн нислэгийн зам болон VFR нислэг дамжин өнгөрөх замын хооронд буфер зон тогтоосон болохыг бататгах;

(2) НХУ-ын үйлчилгээ үзүүлж байгаа улсын ICAO-ийн үндэсний харьяаллын үсгэн кодын араас «Т» үсэг болон тоо дагалдуулж VFR нислэгийн дамжин өнгөрөх замыг тэмдэглэх.

(d) VFR нислэгийн дамжин өнгөрөх зам нь G ангиллын агаарын зай бөгөөд зөвхөн өдрийн цагаар идэвхтэй байна.

71.59. Ерөнхий зориулалтын нисэхийн бүс

(a) Дарга өмнө нь хяналттай агаарын зай байсан хэсэгт НХУ-ын зөвшөөрөл авах шаардлагагүйгээр VFR нислэг нэвтрэхийг зөвшөөрөх зорилгоор хяналттай агаарын зайн хэсгийг нислэгийн ерөнхий зориулалтын нисэхийн бүсээр тогтоож болно.

(b) Ерөнхий зориулалтын нисэхийн бүсийн хувьд Дарга дараах үүрэгтэй:

(1) Дарга агаарын зайг тогтоох үед тухайн бүсэд НХУ-ын үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээсэн НХУ-ын нэгжийг тогтоох;

(2) НХУ-ын үйлчилгээ үзүүлж байгаа улсын ICAO-ийн үндэсний харьяаллын үсгэн кодын араас «G» үсэг болон тоо дагалдуулж тухайн бүсийг тэмдэглэх;

(3) бүсийг дараах тохиолдолд идэвхтэй гэж тогтоох:

(i) өдрийн цагаар байнга; эсхүл

(ii) тухайн агаарын зайг хариуцсан НХУ-ын нэгжийн

зөвшөөрлөөр; эсхүл

(iii) тухайн агаарын зайг хариуцсан НХУ-ын нэгжид тухайн агаарын зайг ашигладаг этгээдийн урьдчилан өгсөн мэдээллээр.

(с) Ерөнхий зориулалтын нисэхийн бүс нь:

(1) зөвхөн өдрийн цагаар идэвхтэй байна;

(2) идэвхтэй байх үедээ G ангиллын агаарын зайд хамаарна.

71.61. Туслах агаарын зайг тогтоох

(а) Дарга нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхол, нислэгийн хөдөлгөөний зохицуулалт, эсхүл олон улсын гэрээ хэлэлцээрийн дагуу шаардлагатай гэж үзвэл хяналттай агаарын зай, эсхүл хяналттай агаарын зайн хэсгийг дараах аль ч хэлбэрээр тогтоож болно:

(1) нислэгийн хөдөлгөөний нягтрал, НХУ-ний замын бүтэц болон агаарын хөлгийн навигацийн системийн нарийвчлалыг харгалзан Навигацийн шаардлагатай үзүүлэлт (RNP)-тэй агаарын зайгаар;

(2) нислэгийн хөдөлгөөний нягтрал, НХУ-ний замын бүтэц болон агаарын хөлгийн өндрийн системийн нарийвчлалыг харгалзан Багасгасан босоо зайчлалын минимум (RVSM) агаарын зайгаар.

С Бүлэг - Агаарын зайн ангилал

71.101. А ангиллын агаарын зай

(а) Дарга нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхлын үүднээс шаардлагатай гэж үзвэл дараах тохиолдолд 71.51(а)-ийн дагуу удирдлагын бүс, эсхүл удирдлагын зоноор тогтоосон агаарын зайн аливаа хэсгийг А ангиллын агаарын зай гэж ангилна:

(1) бүх нислэгүүдийн хооронд зайчлал шаардлагатай бол;

(2) VFR нислэгийг зөвшөөрөхгүй бол.

71.103. В ангиллын агаарын зай

(а) Дарга нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхлын үүднээс бүх нислэгүүдийн хооронд зайчлал шаардлагатай гэж үзвэл 71.51(а) хэсгийн дагуу удирдлагын бүс, эсхүл удирдлагын зоноор тогтоосон агаарын зайн аливаа хэсгийг В ангиллын агаарын зай гэж ангилж болно.

71.105. С ангиллын агаарын зай

(а) Дарга дараах тохиолдолд нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхлын үүднээс 71.51(а) хэсгийн дагуу удирдлагын бүс, эсхүл удирдлагын зоноор тогтоосон агаарын зайн аливаа хэсгийг С ангиллын агаарын зай гэж ангилна:

(1) дараах нислэгийн хооронд зайчлал шаардлагатай гэж үзвэл:

(i) IFR нислэгийн хооронд;

(ii) IFR болон VFR нислэг;

(iii) IFR болон тусгай VFR нислэг;

(iv) нислэгийн хараа 5 км-ээс бага бол, тусгай VFR нислэгийн хооронд;

(2) VFR нислэгийг бусад VFR нислэгийн хөдөлгөөний талаар мэдээллээр хангах шаардлагатай гэж үзвэл;

(3) хүсэлт гаргасан бол VFR нислэгийг нислэгийн хөдөлгөөнөөс зайлсхийх зөвлөмжөөр хангах шаардлагатай гэж үзвэл.

71.107. D ангиллын агаарын зай

(а) Дарга дараах тохиолдолд нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхлын үүднээс 71.51(а) хэсгийн дагуу удирдлагын бүс, эсхүл удирдлагын зоноор тогтоосон агаарын зайн аливаа хэсгийг D ангиллын агаарын зай гэж ангилна:

(1) дараах нислэгүүдийн хооронд зайчлал шаардлагатай гэж үзвэл:

(i) IFR нислэгийн хооронд;

(ii) IFR болон тусгай VFR нислэг;

(iii) нислэгийн хараа 5 км-ээс бага бол, тусгай VFR нислэгийн хооронд;

(2) нислэгийн хөдөлгөөний мэдээллээр хангах шаардлагатай гэж үзвэл:

(i) VFR нислэгийн талаар IFR нислэгийг;

(ii) IFR нислэгийн талаар VFR нислэгийг;

(iii) бусад VFR-ийн нислэгийн талаар VFR нислэгийг;

(3) хүсэлт гаргасан бол IFR болон VFR нислэгийг нислэгийн хөдөлгөөнөөс зайлсхийх зөвлөмжөөр хангах шаардлагатай гэж үзвэл.

71.109. E ангиллын агаарын зай

(а) Дарга дараах тохиолдолд нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхлын үүднээс 71.51(а)-ийн дагуу удирдлагын бүсээр тогтоосон агаарын зайн аливаа хэсгийг E ангиллын агаарын зай гэж ангилна:

(1) IFR-ийн нислэгийн хооронд зайчлал шаардлагатай гэж үзвэл;

(2) боломжтой тохиолдолд нислэгийн хөдөлгөөний мэдээллээр хангах шаардлагатай гэж үзвэл:

(i) VFR нислэгийн талаар IFR нислэгийг;

(ii) IFR нислэгийн талаар VFR нислэгийг;

(iii) бусад VFR нислэгийн талаар VFR нислэгийг.

71.111. F ангиллын агаарын зай

(а) Дарга дараах тохиолдолд нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхлын үүднээс хяналтгүй агаарын зайн аливаа хэсгийг F ангиллын агаарын зайгаар ангилж болно:

(1) тухайн агаарын зайд IFR нислэг нислэгийн хөдөлгөөний зөвлөмжийн үйлчилгээ авах шаардлагатай гэж үзвэл;

(2) хүсэлт гаргасан бол тухайн агаарын зайд бүх нислэг нислэгийн мэдээллийн үйлчилгээ авах шаардлагатай гэж үзвэл.

71.113.Г ангиллын агаарын зай

(а) F ангиллын агаарын зайгаас бусад хяналтгүй агаарын зай нь G ангиллын агаарын зай байх ба:

(1) IFR нислэг нь нислэгийн мэдээллийн үйлчилгээ авах эрхтэй;

(2) хүсэлт гаргасан бол VFR нислэг нь нислэгийн мэдээллийн үйлчилгээ авах эрхтэй.

D Бүлэг - Тусгай зориулалтаар ашиглах агаарын зай

71.151. Ерөнхий зүйл

(а) Дарга агаарын зайг дараах үндэслэлээр шаардлагатай гэж үзвэл энэ бүлгийн дагуу тусгай зориулалтаар ашиглах агаарын зайг тогтоож болно:

(1) иргэний нисэхийн аюулгүй байдал, эсхүл аюулгүйн хамгаалалтын ашиг сонирхлын үүднээс; эсхүл

(2) үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхлын үүднээс; эсхүл

(3) нийтийн ашиг сонирхолд нийцэх бусад шалтгааны улмаас.

(b) Дарга энэ бүлгийн дагуу тогтоосон агаарын зайн хэсэг нь бүсийн шаардлагатай үйл ажиллагаанд нийцсэн аль болох бага талбайтай байгааг бататгана.

(c) Энэ бүлгийн дагуу Даргын тогтоосон агаарын зайг энэ дүрмийн дагуу тогтоосон бусад агаарын зайн хэсгийг тэмдэглэхэд хэрэглэгдээгүй үсэг ба араас нь тоо дагалдуулсан оноосон нэрээр тэмдэглэсэн байна.

71.153. Хязгаарлалттай бүс

(а) Дарга дараах эрхийг хэрэгжүүлнэ:

(1) Монгол Улсын нутаг дэвсгэрийн хил хязгаар дотор агаарын хөлгийн үйл ажиллагааг хязгаарлах зорилгоор агаарын зайн хэсгийг хязгаарлалттай бүсээр тогтоож болно;

(2) дараах нөхцөлийг тогтооно:

(i) тухайн хязгаарлалттай бүсэд агаарын хөлөг нисэхийг зөвшөөрч болох;

(ii) тухайн хязгаарлалттай бүсийг хариуцах эрх бүхий байгууллагын үйл ажиллагаа гүйцэтгэх.

(b) Дарга дараах үүрэгтэй:

(1) тухайн хязгаарлалттай бүсийн зориулагдсан үйл ажиллагааны төрлийг тогтоох;

(2) хязгаарлалттай бүсийн үйл ажиллагааг хариуцсан эрх бүхий байгууллагыг тогтоох;

(3) тухайн улсын ICAO-ийн үндэсний харьяаллын үсгэн кодын

араас «Р» үсэг болон тоо дагалдуулж бүсийг тэмдэглэх.

(с) Хязгаарлалттай бүсийг хариуцсан эрх бүхий байгууллага нь:

(1) дараах үйл ажиллагааг удирдах үүрэгтэй:

(i) агаарын хөлөг хязгаарлалттай бүсэд нэвтрэх;

(ii) хязгаарлалттай бүс доторх агаарын хөлгийн;

(iii) агаарын хөлөг хязгаарлалттай бүсээс гарах;

(2) хэрэв хязгаарлалттай бүс нь NOTAM-аар идэвхтэй болдог байхаар тогтоогдсон бол хязгаарлалттай бүс идэвхтэй болохоос 24-өөс доошгүй цагийн өмнө Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллага (НМҮБ)-д тухайн хязгаарлалттай бүс нь идэвхтэй болох мэдэгдлийг өгөх үүрэгтэй. Онцгой нөхцөлийн үед 24 цагаас бага хугацаанд мэдэгдэл өгч болно;

(3) энэ зүйлийн (а)(2)(ii)-ын дагуу Даргын тогтоосон нөхцөлийн хүрээнд тухайн хязгаарлалттай бүсэд үйл ажиллагаа гүйцэтгэх агаарын хөлөгт нөхцөл тогтоож болно.

71.155. Цэргийн үйл ажиллагааны бүс

(а) Дарга дараах эрхийг хэрэгжүүлнэ:

(1) цэргийн үйл ажиллагааг бусад нислэгийн хөдөлгөөнөөс тусгаарлах зорилгоор агаарын зайн хэсгийг цэргийн үйл ажиллагааны бүсээр тогтоож болно;

(2) дараах нөхцөлийг тогтоож болно:

(i) цэргийн үйл ажиллагааны бүсэд агаарын хөлөг нисэхийг зөвшөөрч болох;

(ii) энэ зүйлийн (b)(2)-т заасан, хариуцсан эрх бүхий байгууллагын үйл ажиллагаа гүйцэтгэх.

(b) Дарга дараах үүрэгтэй:

(1) цэргийн үйл ажиллагааны бүсийн зориулагдсан үйл ажиллагааны төрлийг тогтоох;

(2) цэргийн үйл ажиллагааны бүсийн үйл ажиллагааг хариуцсан эрх бүхий байгууллагыг тогтоох;

(3) тухайн улсын ИCAO-ийн үндэсний харьяаллын үсгэн кодын араас «М» үсэг болон тоо дагалдуулж цэргийн үйл ажиллагааны бүсийг тэмдэглэх.

(с) Цэргийн үйл ажиллагааны бүсийг хариуцсан эрх бүхий байгууллага нь:

(1) дараах үйл ажиллагааг удирдах үүрэгтэй:

(i) агаарын хөлөг цэргийн үйл ажиллагааны бүсэд нэвтрэх;

(ii) цэргийн үйл ажиллагааны бүсийн доторх агаарын хөлгийн;

(iii) агаарын хөлөг цэргийн үйл ажиллагааны бүсээс гарах;

(2) хэрэв цэргийн үйл ажиллагааны бүс нь NOTAM-аар идэвхтэй болдог байхаар тогтоогдсон бол цэргийн үйл ажиллагааны

бүс идэвхтэй болохоос 24-өөс доошгүй цагийн өмнө НМҮБ-д тухайн цэргийн үйл ажиллагааны бүс нь идэвхтэй болох мэдэгдлийг өгөх үүрэгтэй. Онцгой нөхцөлийн үед 24 цагаас бага хугацаанд мэдэгдэл өгч болно;

(3) энэ зүйлийн (а)(2)(ii)-ын дагуу Даргын тогтоосон нөхцөлийн хүрээнд тухайн цэргийн үйл ажиллагааны бүсэд үйл ажиллагаа гүйцэтгэх агаарын хөлөгт нөхцөл тогтоож болно.

71.157. Радио нэвтрүүлэг шаардлагатай зон

(а) Хэрэв хөдөлгөөний нягтрал, эсхүл тусгай нөхцөлөөс шалтгаалан тухайн зоны хүрээнд нисгэгч нь байрлал болон зорилгоо радио холбоогоор мэдээлэх шаардлагатай бол Дарга хяналтгүй агаарын зайн хэсгийг радио нэвтрүүлэг шаардлагатай зоноор тогтоож болно.

(b) Дарга дараах үүрэгтэй:

(1) тухайн улсын ICAO-ийн үндэсний харьяаллын үсгэн кодын араас «В» үсэг болон тоо дагалдуулж, радио нэвтрүүлэг шаардлагатай зоныг тэмдэглэх;

(2) радио нэвтрүүлэг шаардлагатай зонд хэрэглэх радио холбоо мэдээлэх давтамжийг тогтоох;

(3) нисгэгч радио холбоо мэдээлэх максимум интервалыг заах.

71.159. Галт уулын аюулын зон

(а) Хэрэв галт уулын идэвхжил (шидэгдсэн чулуу, хийн бамбар, үнсэн үүл гэх мэт) нь агаарын хөлөгт аюул учруулж болох бол Дарга агаарын зайн хэсгийг галт уулын аюулын зоноор тогтоож болно.

(b) Дарга тухайн улсын ICAO-гийн үндэсний харьяаллын үсгэн кодын араас «V» үсэг болон тоо дагалдуулж галт уулын аюулын зоныг тэмдэглэнэ.

71.161. Аюултай бүс

(а) Тухайн бүсэд агаарын хөлөг нисэхэд бодит аюул байгааг үйл ажиллагаа эрхлэгчид мэдэгдэх зорилгоор Дарга агаарын зайн хэсгийг аюултай бүсээр тогтоож болно.

(b) Дарга дараах үүрэгтэй:

(1) тогтоосон аюултай бүсийн аюулын шинж чанарыг тогтоох;

(2) хэрэв шаардлагатай гэж үзвэл хэрэглэгч байгууллагыг аюултай бүсийн холбоо барих этгээдээр томилох;

(3) тухайн улсын ICAO-ийн үндэсний харьяаллын үсгэн кодын араас «D» үсэг болон тоо дагалдуулж тухайн бүсийг тэмдэглэх.

(c) Аюултай бүсийн хэрэглэгч байгууллага нь дараах үүрэгтэй:

(1) аюултай бүсийг тогтоох шалтгаан болсон ажиллагааны хариуцлага хүлээсэн этгээд, эсхүл байгууллага байх;

(2) аюултай бүсийг тогтоох шалтгаан болсон ажиллагаа нь тогтоосон аюултай бүсийн дотор хийгдэхийг бататгах;

(3) хэрэв аюултай бүс нь NOTAM-аар идэвхтэй болдог байхаар тогтоогдсон бол аюултай бүс идэвхтэй болохоос 24-өөс доошгүй цагийн өмнө НМУБ-д тухайн аюултай бүс нь идэвхтэй болох мэдэгдлийг өгөх үүрэгтэй. Онцгой нөхцөлийн үед 24 цагаас бага хугацаанд мэдэгдэл өгч болно.

71.163. Нам өндрийн нислэгийн зон

(а) Дарга нам түвшний маневрын нисгэгчийн сургалтыг гүйцэтгэж болох агаарын зайн хэсгийг нам өндрийн нислэгийн зоноор тогтоож болно.

(b) Дарга дараах үүрэгтэй:

(1) дараах үйл ажиллагааг хариуцах хэрэглэгч байгууллагыг томилох:

(i) нам өндрийн нислэгийн зоны доорх газар ба усан гадаргыг хариуцсан бүртгэлтэй өмчлөгч, эсхүл зохион байгуулагчтай зөвшилцсөн ашиглалтын холбогдох нөхцөлийн талаар нисгэгчид заавар өгөх;

(ii) энэ зүйлийн (е) болон (f) хэсгийг дагаж мөрдөх;

(2) тухайн улсын ICAO-ийн үндэсний харьяаллын үсгэн кодын араас «L» үсэг болон тоо дагалдуулж, нам өндрийн нислэгийн зоныг тэмдэглэх.

(c) Нам өндрийн нислэгийн зон нь зөвхөн өдрийн цагаар идэвхтэй байна.

(d) Нам өндрийн нислэгийн зоны босоо хязгаар нь газар ба усан гадаргаас дээш 150 м (500 ft)-ийн өндөр хүртэл үргэлжилсэн байх ёстой.

(е) Тухайн нам өндрийн нислэгийн зоныг ашиглахаар томилогдсон хэрэглэгч байгууллага дараах шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд Дарга агаарын зайн хэсгийг нам өндрийн нислэгийн зоноор тогтоож болохгүй:

(1) нам өндрийн нислэгийн зоны хил, хязгаарыг тогтоосон газрын зураг, эсхүл нислэгийн зургийг Даргад хүргүүлсэн байх;

(2) нам өндрийн нислэгийн зоны доорх газар, эсхүл усан гадаргууг хариуцсан бүртгэлтэй өмчлөгч, эсхүл зохион байгуулагч нь тэдний газар, эсхүл усан дээрх агаарын зайн тухайн хэсгийг нам өндрийн нислэгт ашиглахыг зөвшөөрснийг Дарга хангалттай гэж үзсэн байх;

(3) бусад агаарын зайг ашигладаг этгээдтэй зөвшилцсөн дэлгэрэнгүй мэдээллийг Даргад хүргүүлсэн байх.

(f) Энэ зүйлийн (b)(1)-ийн дагуу томилогдсон хэрэглэгч байгууллага нь шаардлагатай тохиолдолд энэ зүйлийн (е)(2)-ыг үргэлжлүүлэн

хангаж байгаагаа Даргад нотлох үүрэгтэй.

71.165. Хориотой бүс

(а) Дарга эрх бүхий бусад холбогдох байгууллагуудтай зөвшилцсөний үндсэн дээр Монгол Улсын нутаг дэвсгэр дэх агаарын зайн тодорхой бүс, хэсэгт байнгын эсвэл түр хугацаагаар хориг тавьж болно.

(б) Дарга дараах үүрэгтэй:

(1) тогтоосон хориотой бүсийн төрөл хэлбэрийг тогтоох;

(2) энэ ажиллагаанд оролцож хяналт тавих эрх бүхий этгээдийг тодорхойлох;

(3) тухайн улсын ICAO-ийн үндэсний харьяаллын үсгэн кодын араас “P” үсэг болон тоо дагалдуулж тухайн бүсийг тэмдэглэх.

(с) Хориотой бүсийн үйл ажиллагаанд оролцож хяналт тавих эрх бүхий этгээд нь дараах үүрэгтэй:

(1) хориотой бүсэд хяналт тавих;

(2) онцгой нөхцөл, эрэн хайх авран туслах ажиллагаанаас бусад тохиолдолд хориотой бүс нь NOTAM-аар идэвхтэй болдог байхаар тогтоогдсон бол хориотой бүс идэвхтэй болохоос 14-өөс доошгүй хоногийн өмнө эрх бүхий байгууллагад мэдэгдэх;

(3) бүсийн хорио, хязгаар, хугацааг 24-өөс доошгүй цагийн өмнө НМУБ-д тухайн хориотой бүс нь идэвхтэй болох мэдэгдлийг өгөх үүрэгтэй. Онцгой нөхцөлийн үед 24 цагаас бага хугацаанд мэдэгдэл өгч болно.

Е Бүлэг - Транспондер шаардлагатай агаарын зай

71.201. Хяналттай агаарын зай дахь транспондер шаардлагатай агаарын зай

(а) Дарга удирдлагын бүс, эсхүл удирдлагын зон, эсхүл тэдгээрийн аливаа хэсгийг дараах тохиолдолд транспондер шаардлагатай агаарын зайгаар тогтоож болно:

(1) НХУ-ын ажиглалтын үйлчилгээнд транспондерийн үйл ажиллагаа шаардлагатай бол; эсхүл

(2) тухайн агаарын зай дахь хөдөлгөөний нягтрал нь Агаарт мөргөлдөхөөс урьдчилан сэргийлэх систем (цаашид “ACAS” гэх)-ээр тоноглогдсон байхыг шаардсан агаарын хөлгийн агаарт мөргөлдөх эрсдэлийг багасгах зорилгоор транспондерийн үйл ажиллагаа шаардаж байгааг тодорхойлсон бол.

71.203. Тусгай зориулалтаар ашиглах агаарын зай дахь транспондер шаардлагатай агаарын зай

(а) Дарга тухайн агаарын зай дахь хөдөлгөөний нягтрал нь ACAS-ээр тоноглогдсон байхыг шаардсан агаарын хөлгийн агаарт мөргөлдөх эрсдэлийг багасгах зорилгоор транспондерийн үйл ажиллагаа шаардаж

байгааг тогтоовол тусгай зориулалтаар ашиглах агаарын зайн аливаа хэсгийг транспондер шаардлагатай агаарын зайгаар тогтоож болно.

F Бүлэг - Бусад

71.251. Ил харааны илтгэх цэг

(а) Дарга дараах зорилгоор ил харааны илтгэх цэгийг тогтоож болно:

(1) нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн байрлалын мэдээлэл өгөх НХҮ-ний шаардлагыг хялбаршуулах; эсхүл

(2) ил харааны цэгээр баримжаалан нислэгийг аюулгүй гүйцэтгэх явдлыг хөнгөвчлөх.

(b) Дарга ил харааны илтгэх цэгийг дараах байдлаар тогтоосон болохыг бататгана:

(1) Газар зүйн танигдахуйц онцлог шинж тэмдэгт суурилсан;

(2) нэр, эсхүл оноосон нэр ашиглан дараах хэлбэрээр таних тэмдэглэгээ хийгдсэн:

(i) дуут холбоогоор дамжуулахад хялбар танигдахуйц;

(ii) ижил ерөнхий бүсэд орших бусад илтгэх цэгтэй андуурагдахааргүй;

(iii) нисгэгчийн хооронд болон НХҮ болон нисгэгчийн хооронд солилцох бусад холбоонд үл ойлголцол үүсгэхгээргүй байх.

71.253. Бүсийн QNH зон

(а) Дарга газрын гадаргуугаас тогтоосон түвшин хүртэлх агаарын зайн тодорхой хэсгийг, бүсийн нийтлэг QNH алтиметрийн тохируулга хийгдсэн байх ёстой “бүсийн QNH зон” гэж тогтоож болно.

71.255. Уулархаг зон

(а) Аюулгүй байдлын ашиг сонирхлын үүднээс хэрэв Дарга тухайн агаарын хөлгийн үзүүлэлтэд хуйлрал, доош чиглэсэн урсгал болон цаг уурын аюултай үзэгдлийн болзошгүй нөлөөг тооцохын тулд IFR нислэгийг газрын бартаанаас дээш нэмэлт өндрөөр хангаж, саадыг давах минимум зайг ихэсгэх шаардлагатай гэж үзвэл, Дарга агаарын зайн хэсгийг уулархаг зоноор тогтоож болно.

*Зам, тээврийн сайдын 2025 оны 9 дүгээр сарын
23-ны өдрийн А/236 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт*

**ИНД-77 Нислэг үйлдэх агаарын зайд нөлөөлөх байгууламж, үйл
ажиллагаа**

77.1. Зорилго

(а) Энэ дүрмээр дараах харилцааг зохицуулна:

(1) Монгол Улсын Зэвсэгт хүчний харьяалах бүсийг оролцуулан, Монгол Улсын нутаг дэвсгэрт дараах үйл ажиллагаа гүйцэтгэхийг санал болгож байгаа этгээдэд тавигдах шаардлага:

(i) нислэг үйлдэх агаарын зайд аюул үүсгэж болох байгууламж барих, өөрчлөх; эсхүл

(ii) нислэг үйлдэх агаарын зайд аюул үүсгэж болох байгууламж, гэрэл, лазер, зэвсэг, эсхүл пиротехник ашиглах.

77.2. Хамрах хүрээ

(а) Энэ дүрэм нь дараах агаарын хөлөг болон үйл ажиллагаанд хамаарахгүй:

(1) Монгол Улсын Зэвсэгт хүчний анги салбар, эсхүл дараах үйл ажиллагаатай холбоотой үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын Зэвсэгт хүчний агаарын хөлөг:

(i) дайны, эсхүл бусад онцгой нөхцөл; эсхүл

(ii) Монгол Улсын болон түүний бусад ашиг сонирхлыг хамгаалах; эсхүл

(iii) онцгой нөхцөлийн үед ард иргэдэд тусламж үзүүлэх; эсхүл

(iv) нийтэд чиглэсэн үйлчилгээ үзүүлэх; эсхүл

(v) ИНД-71 Агаарын зайг тогтоох, ангилах (цаашид “ИНД-71” гэх)-ын дагуу цэргийн зорилгоор тогтоосон хязгаарлалттай, аюултай, эсхүл цэргийн үйл ажиллагааны бүсэд гүйцэтгэсэн ажиллагаа;

(2) ИНД-101 Хүнгүй агаарын хөлөг, пуужин, жироглайдер болон парасэйлийн үйл ажиллагааны дүрэмд хамаарах үйл ажиллагаа.

77.3. Нэр томьёо болон товчлол

(а) Энэ дүрэмд хэрэглэх нэр томьёо болон товчлолыг ИНД-1 Нэр томьёоны тайлбарт тусгасан.

77.5. Байгууламж барих, өөрчлөх мэдэгдэл

(а) Байгууламж барих, эсхүл өөрчлөхийг төлөвлөж байгаа этгээд нь дараах тохиолдолд 77.13-ын дагуу саналыг Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга бөгөөд иргэний нисэхийн хяналтын улсын ерөнхий байцаагч (цаашид “Дарга” гэх)-д мэдэгдэх үүрэгтэй. Хэрэв тухайн байгууламж, эсхүл түүний өөрчлөлт нь:

(1) тухайн байрлалын газрын түвшнээс дээш (цаашид “AGL” гэх) 60 м-ээс дээш өргөгдөх бол; эсхүл

(2) тухайн бүсийн модны дундаж өндрөөс 18 м-ээр илүү гарсан ба нам өндөрт агаараас гүйцэтгэх ажиллагааны бүсэд, эсхүл бусад нам өндрийн нислэгийн бүсэд, эсхүл ИНД-71-ийн дагуу тогтоосон нам өндрийн нислэгийн зонд, эсхүл нам түвшний нислэгийн замд байрладаг бол; эсхүл

(3) Хавсралт А-ын А.1 болон А.2 зурагт дүрсэлсэн аэродромын ойртолтын, эсхүл хөөрөлтийн гадаргуугаас доош байрладаг, Хавсралт А-д тодорхойлсон гадаргуугаас дээш өндөрт хүрсэн байх бөгөөд энэ гадаргуу нь дараах нөхцөлийн дагуу гадагш болон дээш чиглэн тэлдэг бол:

(i) Гэрчилгээжсэн максимум хөөрөлтийн жин (цаашид “MCTOW” гэх) нь 5,700 кг-аас дээш жинтэй агаарын хөлөг ашигладаг, эсхүл ашиглахаар төлөвлөж байгаа бол хөөрч, буух зурвас (цаашид “ХБЗ” гэх)-ын хөөрөлтийн гадаргуугийн эхлэл цэгээс эхлэх 1:83 харьцаа бүхий налуу;

(ii) MCTOW нь 5,700 кг, эсхүл түүнээс доош жинтэй агаарын хөлөг ашигладаг, эсхүл ашиглахаар төлөвлөж байгаа бол ХБЗ-ын хөөрөлтийн гадаргуугийн эхлэл цэгээс эхлэх 1:50 харьцаа бүхий налуу;

(iii) хэлипортын аюулгүй байдлын бүсийн хамгийн ойрын цэгээс эхлэх 1:25 харьцаа бүхий налуу; эсхүл

(4) аэродромын конус, дотор талын хэвтээ, эсхүл шилжилтийн хажуу гадаргууг огтолсон бол:

(i) Хавсралт А-ийн А.1-д дүрсэлсэн; эсхүл

(ii) ИНД-139 [Аэродромын үйл ажиллагаа, гэрчилгээжүүлэлт](#)-д заасан; эсхүл

(iii) тухайн орон нутгийн газрын зурагт тогтоосон.

77.7. Агаарын урсгал (efflux), гэрэл, эсхүл лазер үүсгэх байгууламж ашиглах мэдэгдэл

(a) Байгууламжийг ашиглахаар санал болгож байгаа этгээд нь дараах тохиолдолд 77.13-ын дагуу саналыг Даргад мэдэгдэх үүрэгтэй:

(1) тухайн байгууламж нь аэродромын саадыг хязгаарлах бүсийг огтлон 4.3 м/с-ээс дээш хурдтай агаарын урсгал үүсгэх бол; эсхүл

(2) тухайн байгууламж нь AGL 60 м-ээс дээш өндөрт 4.3 м/с-ээс дээш хурдтай агаарын урсгал үүсгэх бол.

(b) Гэрэл, лазерыг ашиглахаар санал болгож байгаа этгээд нь дараах тохиолдолд 77.13-ын дагуу Даргад мэдэгдэх үүрэгтэй:

(1) гэрэл, лазер нь нисгэгчийн харааг гялбуулах, эсхүл бусдаар нөлөөлснөөр агаарын хөлөгт аюул учруулах бол; эсхүл

(2) [хүчингүй болгосон]

(3) дараах алдаанаас үүдэн агаарын хөлөгт аюул учруулах бол:

(i) аэродромд, эсхүл түүний ойролцоо байрлуулсан, эсхүл байрлуулахыг зөвшөөрсөн гэрэл, эсхүл гэрлийн системийн хэсэг; эсхүл

(ii) нислэг үйлдэх агаарын зайн аюулыг тэмдэглэсэн гэрлэн тэмдэглэгээ.

77.9. Зэвсэг хэрэглэх мэдэгдэл

(а) Хэрэв аливаа этгээд дараах өндрөөс дээш нисэх траектортой гэрэлт пуужин, сум хөөргөх, эсхүл буудах зэвсэг хэрэглэхээр төлөвлөж байгаа бол 77.13-ын дагуу Даргад мэдэгдэх үүрэгтэй:

(1) аэродромын хил хязгаараас 4 км-ийн дотор бол 45 м; эсхүл

(2) аэродромын хил хязгаараас 4 км-ээс хол зайтай бол 120 м.

77.11. Пиротехник ашиглах мэдэгдэл

(а) Хэрэв аливаа этгээд дараах өндрөөс дээш нисэх траектортой гэрэлт пуужин, сум хөөргөх, эсхүл буудах ажиллагаа оролцсон пиротехникийн үзүүлбэр хийхээр санал болгож байгаа бол 77.13-ын дагуу Даргад мэдэгдэх үүрэгтэй:

(1) аэродромын хил хязгаараас 4 км-ийн дотор бол 45 м; эсхүл

(2) аэродромын хил хязгаараас 4 км-ээс хол зайтай бол 120 м.

77.13. Мэдэгдэлд тавигдах шаардлага

(а) Энэ зүйлийн (b) болон (c)-ийг харгалзан, 77.5, 77.7, 77.9, эсхүл 77.11-ийн дагуу Даргад мэдэгдэх шаардлагатай этгээд нь САА 24077/01 маягтыг бөглөж, дараах хугацаанд Даргад хүргүүлэх үүрэгтэй:

(1) 77.5-ын дагуу байгууламж барих, өөрчлөхөөр санал болгосон өдрөөс 90 хоногийн өмнө; эсхүл

(2) 77.7, 77.9, эсхүл 77.11-ийн дагуу ашиглахаар санал болгосон өдрөөс ажлын 5 хоногийн өмнө.

(b) Байгууламжийг яаралтай барих, өөрчлөх, эсхүл байгууламж, гэрэл, лазер, зэвсэг, эсхүл пиротехник ашиглахыг шаардсан, нийтийн зайлшгүй үйлчилгээ, нийтийн эрүүл мэнд, эсхүл нийтийн аюулгүй байдалтай холбоотой онцгой нөхцөл бий болсон тохиолдолд:

(1) энэ зүйлийн (a)-д заасан мэдэгдлийн шаардлага хамаарахгүй;

(2) тухайн байгууламжийг барих, өөрчлөх, эсхүл ашиглахыг хариуцсан этгээд нь тухайн байгууламжийг барьж, өөрчилж, эсхүл ашигласнаас хойш ажлын 5 хоногийн дотор САА 24077/01 маягтыг бөглөж, Даргад хүргүүлэх үүрэгтэй.

(c) Холбогдох Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ (НХҮ)-ний нэгж хяналт тавьж байгаа үед ИНД-71-ийн дагуу тогтоосон хяналттай зонд гэрэл, лазер, зэвсэг, эсхүл пиротехник ашиглахаар санал болгож байгаа

этгээдийг:

(1) энэ зүйлийн (а) хэсгийн дагуу мэдэгдэл хүргүүлэхийг шаардахгүй;

(2) тухайн агаарын зайг хариуцсан НХУ-ын нэгжээс ашиглалт эхлэхээс өмнө ажлын 5 хоногт өгсөн байх шаардлагатай урьдчилсан зөвшөөрөлгүйгээр хяналттай зонд гэрэл, лазер, зэвсэг, эсхүл пиротехник ашиглахыг зөвшөөрөхгүй.

77.15. Нэмэлт мэдэгдэлд тавигдах шаардлага

(а) Энэ дүрмийн 77.5 болон 77.7-ийн дагуу Даргад мэдэгдэх шаардлагатай этгээд нь хэрэв Дарга шаардвал, байгууламж барих, өөрчлөх, эсхүл ашиглаж эхлэх аль хамааралтай огноог Даргад бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

(б) Байгууламж барих, эсхүл өөрчлөх талаар 77.5-ын дагуу Даргад мэдэгдэх шаардлагатай этгээд нь, тухайн байгууламж өөрийн хамгийн дээд өндөрт хүрсэн үед ажлын 5 хоногийн дотор Даргад бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

(с) Тухайн байгууламж өөрийн хамгийн дээд өндөрт хүрсэн үед, энэ зүйлийн (б)-д шаардсан мэдэгдэл нь бүртгэлтэй геодезийн ажилтны гаргасан, тухайн байгууламжийн өндөр, байршлын тодорхойлолт болон 77.21(d)-ийн дагуу Даргын тогтоосон тэмдэглэгээ, гэрэлтүүлгийн шаардлагын нийцлийн баталгааг агуулсан байна.

(д) Энэ дүрмийн 77.5-ын дагуу мэдэгдэл гаргах байгууламжийг барих, эсхүл өөрчлөх төслийг зогсоосон этгээд нь тухайн төслийг зогсоосноос хойш ажлын 5 хоногийн дотор Даргад бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

(е) Байгууламжийг буулгаж байгаа, эсхүл нураасан байгууламжийг хариуцагч этгээд хэрэв тухайн байгууламж нь 77.5-ын дагуу мэдэгдлийн шалгуурыг хангасан бол тухайн байгууламжийг буулгасан, эсхүл нурааснаас хойш ажлын 5 хоногийн дотор Даргад бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

77.17. Нисэхийн судалгаа

(а) Дарга 77.5, 77.7, 77.9, эсхүл 77.11-ийн дагуу мэдэгдэл хүлээн авч, тухайн саналыг хэрэгжүүлсэн тохиолдолд нислэг үйлдэх агаарын зайд аюул үүсгэх эсэхийг тогтоох зорилгоор нисэхийн судалгаа хийнэ.

(б) Дарга нисэхийн судалгааг хийхдээ хамааралтай гэж үзсэн этгээд, нисэхийн салбарын болон бусад байгууллага, төлөөллийн бүлэгтэй зөвлөлдөнө.

77.19. Аюулыг тогтоох стандарт

(а) Хэрэв байгууламж нь тухайн байрлалын AGL 120 м, эсхүл түүнээс өндөр бол Дарга тухайн байгууламжийг нислэг үйлдэх агаарын зайд аюултай болохыг тогтооно.

(b) Хэрэв байгууламж нь тухайн аэродромд хамааралтай саадыг хязгаарлах гадаргууг дайрч 4.3 м/с-ээс дээш хурдтай агаарын урсгал үүсгэх, эсхүл үүсэхээр байвал Дарга тухайн байгууламжийн ашиглалт нь нислэг үйлдэх агаарын зайд аюултай болохыг тогтооно.

(c) Хэрэв байгууламж нь AGL 120 м-ээс дээш өндөрт, 4.3 м/с-ээс дээш хурдтай агаарын урсгал үүсгэх, эсхүл үүсгэж болох бол Дарга тухайн байгууламжийн ашиглалт нь нислэг үйлдэх агаарын зайд аюултай болохыг тогтооно.

(d) Хэрэв тухайн гэрлийн хэрэглээ нь нислэг үйлдэх агаарын зайд аюул үүсгэхийг дүн шинжилгээгээр илрүүлсэн бол Дарга тухайн гэрлийн хэрэглээ нислэг үйлдэх агаарын зайд аюултай болохыг тогтооно.

(e) [Хүчингүй болгосон]

(f) Хэрэв зэвсгийн хэрэглээ нь нислэг үйлдэх агаарын зайд аюул үүсгэхийг дүн шинжилгээгээр илрүүлсэн бол Дарга тухайн зэвсгийн хэрэглээ нислэг үйлдэх агаарын зайд аюултай болохыг тогтооно.

(g) Хэрэв пиротехникийн хэрэглээ нь нислэг үйлдэх агаарын зайд аюул үүсгэхийг дүн шинжилгээгээр илрүүлсэн бол Дарга тухайн пиротехникийн хэрэглээ нислэг үйлдэх агаарын зайд аюултай болохыг тогтооно.

(h) Дарга саналын тодорхой нөхцөлд үндэслэн, дараах тохиолдолд тухайн байгууламж нь нислэг үйлдэх агаарын зайд аюултай болохыг тогтоож болно:

(1) тухайн байгууламж нь Олон улсын иргэний нисэхийн байгууллагын баримт бичиг Doc 8168-д заасан хэрэглэлийн нислэгийн журмын бүсэд байрладаг, стандарт нисэн ирэх нислэгийн зам, эхний, дунд, төгсгөлийн, ил харааны болон ойртолтоос 2-т гарах сегментийн бүс, нисэн гарах бүс болон нисэн гарах стандарт хэрэглэлийн нислэгийн замыг багтаасан бөгөөд дараах нөлөө үзүүлэх бол:

(i) тухайн бүс, эсхүл сегментийн доторх байгууламжийн цэг болон тогтоосон хэрэглэлийн нислэгийн минимум түвшний хоорондын босоо зай нь хэрэглэлийн нислэгийн журамд шаардсан саадыг давах зайнаас бага байх; эсхүл

(ii) тухайн бүсээс нисэн гарахад хамаарах нэмэлт, эсхүл шинэ үүлний суурийн өндөр, эсхүл алсын барааны харагдцын хязгаарлалт, эсхүл нислэгийн журмын өөрчлөлтөд; эсхүл

(2) мөрдөж байгаа, эсхүл төлөвлөсөн минимум саадыг давах түвшнийг нэмэхийг шаардсан байгууламж нь Монгол Улсын нислэгийн замын дагуух болон бүсийн нислэгийн зураг дээр дүгнэлт хийгдсэн нислэгийн зам багтсан боловч Монгол Улсын Нисэхийн мэдээллийн эмхэтгэл (AIP)-д хэвлэн нийтэлсэн, зурагдсан нислэгийн зам ороогүй Хэрэглэлийн нислэгийн дүрмийн нислэг (IFR нислэг)-ийн замын дагуух

саадыг давах бүсэд байрладаг бол; эсхүл

(3) байгууламж нь тухайн бүсийн модны дундаж өндрөөс 18 м-ээр илүү гарсан ба нам өндөрт агаараас гүйцэтгэх ажиллагааны бүсэд, эсхүл бусад нам өндрийн нислэгийн бүсэд, эсхүл ИНД-71-ийн дагуу тогтоосон нам өндрийн нислэгийн зонд, эсхүл нам түвшний нислэгийн замд байрладаг бол; эсхүл

(4) байгууламж нь аэродромын саадыг хязгаарлах гадаргууг нэвтэлдэг бол.

77.21. Шийдвэр гаргах

(а) Дарга 77.13(а)-ийн дагуу байгууламж барих, өөрчлөх, эсхүл ашиглах тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 28 хоногийн дотор тухайн байгууламж, өөрчлөлт, эсхүл ашиглалт хэрэгжсэн тохиолдолд нислэг үйлдэх агаарын зайд аюул учруулах эсэхийг тогтоох шийдвэр гаргаж, мэдэгдэл гаргагч болон тухайн шийдвэрт хамаатай гэж үзсэн бусад этгээдэд мэдэгдэнэ.

(b) Дарга 77.13(а)-ийн дагуу гэрэл, лазер, зэвсэг, эсхүл пиротехник ашиглах мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор тухайн хэрэгслийн ашиглалт хэрэгжсэн тохиолдолд нислэг үйлдэх агаарын зайд аюул учруулах эсэхийг тогтоох шийдвэр гаргаж, мэдэгдэл гаргагч болон тухайн шийдвэрт хамаатай гэж үзсэн бусад этгээдэд мэдэгдэнэ.

(с) Дарга 77.13(с)-ийн дагуу мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын 4 хоногийн дотор, хэрэв тухайн саналыг хэрэгжүүлсэн бол санал болгосон гэрэл, лазер, зэвсэг, эсхүл пиротехник ашиглах нь, нислэг үйлдэх агаарын зайд аюултай болох эсэхийг тогтоох шийдвэр гаргаж, мэдэгдэл гаргагч болон тухайн шийдвэрт хамаатай гэж Дарга үзсэн бусад этгээдэд мэдэгдэнэ.

(d) Дарга шийдвэрийг нисэхийн судалгаагаар илрүүлсэн дутагдалд үндэслэн гаргах бөгөөд:

(1) дараах тохиолдолд аливаа нөхцөл, эсхүл хязгаарлалтыг тогтоож болно:

(i) Хавсралт В-д дүрсэлсэн байгууламжийн тэмдэглэгээ, эсхүл гэрэлтүүлэг;

(ii) нислэг үйлдэх агаарын зайн аюулыг багасгасан болохыг бататгах;

(iii) нислэг үйлдэх агаарын зайд аюулгүй гэж үзсэн шийдвэрт, хүндрэл үүсгэж болох асуудлыг багасгахад шаардлагатай гэж үзсэн;

(2) мэдэгдэлд тавих нэмэлт шаардлагыг тодорхойлж болно.

77.23. Нийцэл

(а) Энэ дүрмийн 77.5, 77.7, 77.9, эсхүл 77.11-ийн дагуу Даргад мэдэгдэл хүргүүлэх этгээд нь 77.21(d)-ийн дагуу тогтоосон шаардлага, нөхцөл, эсхүл хязгаарлалтыг дагаж мөрдөнө.

77.25. Шийдвэрийн хүчинтэй өдөр болон хугацаа

(а) Төлөвлөж байгаа төслийн хувьд:

(1) Дарга 77.27(b)-ийн дагуу эргэн хянах хүсэлт хүлээн авснаас бусад тохиолдолд, 77.13(a)-ийн дагуу мэдэгдсэн байгууламж барих, өөрчлөх, эсхүл ашиглах шийдвэр нь 77.21(a)-ийн дагуу шийдвэр гарсан өдрөөс хойш 28 хоногийн дараа хүчинтэй болно;

(2) Дарга 77.27(b)-ийн дагуу эргэн хянах хүсэлт хүлээн авснаас бусад тохиолдолд, 77.13(a)-ийн дагуу мэдэгдсэн гэрэл, лазер, зэвсэг, эсхүл пиротехник ашиглах шийдвэр нь Даргад хүргүүлсэн САА 24077/01 маягтад заасан ашиглалтыг төлөвлөж байгаа өдрөөс ажлын 5 хоногийн өмнө хүчинтэй болно.

(b) 77.29-ийн дагуу эргэн хянасан, эсхүл сунгаснаас бусад тохиолдолд нислэг үйлдэх агаарын зай аюулгүй болох талаар энэ дүрмийн дагуу гаргах эцсийн шийдвэр нь:

(1) байгууламж барих, өөрчлөх, эсхүл ашиглах үйл ажиллагааны хувьд, тухайн шийдвэр хүчинтэй болсон өдрөөс хойш 18 сарын дараа, эсхүл төлөвлөж байгаа барилга байгууламж барих, өөрчлөх, эсхүл ашиглах шийдвэрийг цуцалсан өдрийн аль түрүүлж болох өдөр хүчингүй болно;

(2) гэрэл, лазер, зэвсэг, эсхүл пиротехник ашиглах үйл ажиллагааны хувьд, САА 24077/01 маягтаар Даргад мэдэгдсэн ажиллагаа дууссан өдөр, эсхүл төлөвлөсөн ажиллагааг цуцалсан өдрийн, аль түрүүлж болох өдөр хүчингүй болно.

(c) Аюултай гэж гарсан эцсийн шийдвэр нь:

(1) 77.25(a)(1), эсхүл 77.27(f)(2)-ын дагуу байгууламж барих, өөрчлөх, эсхүл ашиглах шийдвэрийн хувьд хугацаагүй байх бөгөөд Дарга бичгээр хүчингүй болгож болно;

(2) 77.25(a)(2), эсхүл 77.27(f)(2)-ын дагуу гэрэл, лазер, зэвсэг, эсхүл пиротехник ашиглалтын хувьд, САА 24077/01 маягтад заасан хугацаанд ажиллагааг гүйцэтгэж дууссан өдөр, эсхүл Дарга сунгаж зөвшөөрсөн өдрийн дараах өдөр хүчингүй болно.

77.27. Аюултай гэж үзсэн шийдвэрийг эргэн хянах хүсэлт

(a) Байгууламж барих, эсхүл өөрчлөх, эсхүл байгууламж, гэрэл, лазер, зэвсэг, эсхүл пиротехник ашиглахаар төлөвлөж байгаа этгээд нь Даргын гаргасан аюултай гэж үзсэн шийдвэрийг эргэн хянаж үзэх хүсэлтийг Даргад гаргаж болно.

(b) Аюултай гэж үзсэн шийдвэрийг эргэн хянаж үзэх тухай бичгээр гаргасан хүсэлтийг 77.25(a)-ийн дагуу шийдвэр эцсийн байдлаар хүчинтэй болохоос өмнө Даргад хүргүүлэх бөгөөд:

(1) тухайн хүсэлт нь нисэхийн үндэслэлийг бүрэн тайлбарлан тусгасан байх;

(2) Дарга гаргасан шийдвэр, өөрчлөлт, эсхүл сунгалтаа эргэн хянаж үзэх болсон бодит үндэслэлийг багтаасан ба нисэхийн судалгааны явцад өмнө нь авч үзээгүй, эсхүл хэлэлцээгүй шинэ мэдээлэл, эсхүл баримтыг танилцуулсан байх;

(3) хэрэв эргэн хянах хүсэлт нь үндэслэл дэх алдаа, журам тайлбарласан байдал, аюулын стандартыг хэрэглэсэн байдал, эсхүл бодит байдлын таамаглалын алдаанд үндэслэсэн бол тухайн хүсэлтийн үндэслэлийг тодорхойлж, тайлбарлах.

(с) Энэ зүйлийн (b)-ийн дагуу ирүүлсэн эргэн хянах хүсэлтийг Дарга шалгаж шийдвэрлэх хүртэл шийдвэр хүчинтэй болохгүй.

(d) Энэ зүйлийн (b)-ийн дагуу ирүүлсэн хүсэлтийг Дарга шалгаж үзээд эргэн хянах эсэхийг шийдвэрлэнэ.

(е) Дарга эргэн хянахыг зөвшөөрсөн тохиолдолд:

(1) хэрэв тухайн хүсэлтэд дурдсан асуудал, эсхүл шийдвэрт зөрүү байгаа бол судалгаа хийх болон эргэн хянах асуудлыг хүсэлт гаргагчид мэдэгдэнэ;

(2) 77.21-ийн (a), (b), эсхүл (c)-ийн аль хамааралтай заалтын дагуу шийдвэр гаргахдаа зарцуулсан хугацаанаас бага хугацаанд эргэн хянах ажиллагааг дуусгана.

(f) Хэрэв Дарга эргэн хянах ажиллагаа явуулахаас татгалзахаар шийдвэрлэсэн бол:

(1) тухайн шийдвэрийн талаарх үндэслэлийг хүсэлт гаргагчид мэдэгдэнэ;

(2) эргэн хянах ажиллагааг татгалзсан, эсхүл 77.25(a)-д заасан хугацааны аль сүүлийн хугацаанд шийдвэр нь эцсийн байдлаар хүчинтэй болно.

77.29. Аюулгүй гэж үзсэн шийдвэрийг эргэн хянах, эсхүл сунгах хүсэлт

(a) Дарга энэ дүрмийн дагуу нислэг үйлдэх агаарын зайд аюулгүй гэж үзсэн шийдвэр гаргасан тохиолдолд аливаа этгээд тухайн шийдвэр, түүний хүчинтэй хугацааг сунгахад үндэслэсэн шинэ нөхцөл байдал өөрчлөгдсөнд үндэслэн дараах тохиолдолд тухайн шийдвэрийг эргэн хянах хүсэлтийг Даргад гаргаж болно, хэрэв:

(1) хамааралтай бол санал болгож буй байгууламжийг барих, эсхүл өөрчлөх, суурь тавих зэрэг барилга угсралтын бодит ажил хийгдэж эхлээгүй бол (малталт орохгүй);

(2) тухайн хүсэлтийг нислэг үйлдэх агаарын зайд аюулгүй гэж үзсэн шийдвэрийн хүчинтэй хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө хүргүүлсэн бол.

(b) Нислэг үйлдэх агаарын зайд аюулгүй гэж үзэн шийдвэр гаргасан Дарга нь танилцуулсан хүсэлтийг шалгаж, тухайн шийдвэрийг


эргэн хянаана, эсхүл шийдвэрийн эхний дуусах хугацааг сунгана, эсхүл батална.

(с) Нислэг үйлдэх агаарын зайд аюулгүй гэж үзсэн шийдвэрийн дуусгавар болох хугацааг:


(1) 77.25(b)(1)-ын дагуу Дарга нэг удаа 6 сараас ихгүй хугацаагаар сунгаж болно;

(2) 77.25(b)(2)-ын дагуу Дарга нэг удаа 14 хоногоос ихгүй хугацаагаар сунгаж болно.

Хавсралт А - Гадаргуугийн Саадын Мэдэгдэл



Зураг А.1 - Аэродромын мэдэгдлийн шаардлага



Зураг А.2 - Хелипортын мэдэгдлийн шаардлага

Хавсралт В - Саадыг тодорхойлох ил харааны туслах хэрэгсэл, тэмдэглэгээ

В.1. Саад

(а) Энэ Хавсралтад “саад” гэсэн нэр томъёог 77.21-ийн дагуу Дарга аюултай гэж тогтоосон байгууламжид хамааруулан хэрэглэнэ.

В.2. Тэмдэглэсэн, эсхүл гэрэлтсэн байх саад

(а) Дараахаас бусад тохиолдолд ИНД-139-д шаардсан саадын хязгаарлагдах гадаргуугаас дээш өргөгдсөн суурин саадыг тэмдэглэсэн байх ба хэрэв тухайн аэродромыг шөнийн цагаар ашигладаг бол гэрэлтүүлсэн байна:

(1) саад нь өдрийн цагаар өндөр тодорцтой саадын гэрлээр гэрэлтдэг бол тэмдэглэгээ хийхгүй байж болно;

(2) саад нь гэрэлт цамхаг бөгөөд нисэхийн судалгаагаар гэрэлт цамхгийн гэрэл хангалттай болохыг харуулсан бол гэрэлтүүлэг хийхгүй байж болно;

(3) тэмдэглэгээ, эсхүл гэрэлтүүлгийг дараах тохиолдолд хийхгүй байж болно:

(i) саад нь тэмдэглэгээтэй, эсхүл гэрэлтүүлэгтэй бусад суурин саадаар халхлагдсан; эсхүл

(ii) олон тооны хөдөлгөөнгүй байгууламж, эсхүл газрын бартааны саадтай хайрцгийн хувьд, тогтоосон нислэгийн замаас доош аюулгүй босоо саадыг давах өндрийг бататгах журмыг тогтоосон; эсхүл

(iii) нисэхийн судалгаагаар саад нь үйл ажиллагаанд ноцтой нөлөө үзүүлэхгүй болохыг тогтоосон.

(b) Энэ дүрмийн 77.19-ийн дагуу аюулыг тогтоох стандартыг хангасан, эсхүл түүнээс хэтэрсэн, энэ зүйлийн (а)-д багтаагүй суурин саадыг дараахаас бусад тохиолдолд тэмдэглэсэн, эсхүл гэрэлтүүлсэн байна:

(1) саад нь өдрийн цагаар өндөр тодорцтой саадын гэрлээр гэрэлтдэг бол тэмдэглэгээ хийхгүй байж болно;

(2) саад нь гэрэлт цамхаг бөгөөд нисэхийн судалгаагаар гэрэлт цамхгийн гэрэл хангалттай болохыг харуулсан бол гэрэлтүүлэг хийхгүй байж болно;

(3) дараах тохиолдолд тэмдэглэгээ, эсхүл гэрэлтүүлэг хийхгүй байж болно:

(i) тухайн саад нь тэмдэглэсэн, эсхүл гэрэлтүүлсэн бусад суурин саадаар халхлагдсан бол; эсхүл

(ii) нисэхийн судалгаагаар тухайн саад нь үйл ажиллагаанд ноцтой нөлөө үзүүлэхгүй болохыг тогтоосон бол.

В.3. Ерөнхий зүйл

(а) Тэмдэглэгээтэй байх шаардлагатай бүх суурин саадыг өнгөөр

ялгах ба гэхдээ хэрэв энэ нь тохиромжгүй бол тухайн саадын хэлбэр, хэмжээ, өнгө нь бусад хэлбэрээр тэмдэглэх шаардлагагүй хангалттай тод харагдахуйц байхаас бусад тохиолдолд тэмдэглэгээ, эсхүл дарцгийг тэдгээрт, эсхүл дээр нь байрлуулна.


В.4. Өнгө ашиглах

(а) Хэрэв саадын босоо хавтгайд буух тусгал нь 1,500 мм-ээс бага хоёр хэмжээстэй бол орчны суурь өнгөнд уусахаас бусад тохиолдолд тухайн саадыг тод харагдахуйц ганц улбар шар, эсхүл улаан өнгөний аль нэгээр тэмдэглэсэн байна.

(б) Хэрэв саад нь үргэлжилсэн гадаргуутай ба түүний босоо хавтгайд буух тусгал нь 4,500 мм, эсхүл үүнээс дээш хоёр хэмжээстэй бол дараах байдлаар тэмдэглэсэн байна:

(1) орчны суурь өнгөнд уусахаас бусад тохиолдолд улбар шар ба цагаан, эсхүл улаан болон цагаан өнгөөр хослуулан;

(2) Зураг В.1-т үзүүлсэн тэгш өнцөгт хэлбэрийн хээгээр, талууд нь 1,500 мм-ээс багагүй, 3,000 мм-ээс ихгүй байх бөгөөд ирмэгийг нь хүнд өнгөөр эмжсэн байна.



Зураг В.1 - Тэмдэглэгээний үндсэн загвар

(с) Дараах тохиолдолд саадыг эрс тэс өнгийн судлаар тэмдэглэсэн байна:

(1) хэрэв саад нь үргэлжилсэн гадаргуутай бөгөөд хэвтээ ба босоо хэмжээсийн аль нэг нь 1,500 мм-ээс их, нөгөө хэмжээс нь 4,500 мм-ээс бага бол; эсхүл

(2) хэрэв үзүүлсэн саад нь сараалжин хэлбэртэй бөгөөд босоо, эсхүл хэвтээ хэмжээсийн аль нэг нь 1,500 мм-ээс их бол. Зураг В.1-ийг үз.

(д) Энэ зүйлийн (с)-д заасан өнгөний судал нь:

- (1) хамгийн урт хэмжээстэй перпендикуляр байрлалтай байна;
- (2) хамгийн урт хэмжээсийн ойролцоогоор 1/7-тэй, эсхүл 30 м-ийн аль багатай тэнцүү өргөнтэй байна;
- (3) суурь өнгөнөөс тод харагдахгүй байхаас бусад тохиолдолд улбар шар болон цагаан өнгөөр хослуулан тэмдэглэнэ;
- (4) саадын төгсгөлийн ирмэг судлыг хүнд өнгөөр хүрээлнэ.

(е) Хүснэгт В.1-т үзүүлсэн судлыг сондгой тоотой байлгах, хамгийн захын төгсгөлийн ирмэг нь хүнд өнгөтэй судалтай байхаар тогтоох хялбар томьёололтой байна. Зураг В.1-ийг харж болно.

Хүснэгт В.1 - Судлын өргөн

Хамгийн урт хэмжээс		Судлын өргөн
Дурдсанаас багагүй (м)	Дурдсанаас ихгүй (м)	
1.5	210	хамгийн урт хэмжээсийн 1/7
210	270	хамгийн урт хэмжээсийн 1/9
270	330	хамгийн урт хэмжээсийн 1/11
330	390	хамгийн урт хэмжээсийн 1/13
390	450	хамгийн урт хэмжээсийн 1/15
450	510	хамгийн урт хэмжээсийн 1/17
510	570	хамгийн урт хэмжээсийн 1/19
570	630	хамгийн урт хэмжээсийн 1/21

В.5. Тэмдэглэгээ ашиглах

Саадын дээр, эсхүл түүний дэргэд байрлуулсан тэмдэглэгээг:

- (1) саадын ерөнхий байдлыг тод харагдахуйц байршилд байрлуулна;
- (2) тэнгэр цэлмэг байхад агаарын хөлөг тухайн байгууламжид ойртолт үйлдэж болох бүх талаасаа, дараах зайнаас танигдахуйц байна:
 - (i) агаараас харагдах саадын хувьд, 1,000 м-ээс доошгүй;
 - (ii) газраас харагдах саадын хувьд, 300 м-ээс доошгүй;
- (3) өвөрмөц хэлбэртэй байх ба энэ нь өөр бусад мэдээлэл дамжуулахад ашигладаг тэмдэглэгээтэй андуурахааргүй байна;
- (4) саадын учруулж болох аюулыг нэмэгдүүлэхгүй байхаар тэмдэглэгээ хийнэ.

В.6. Дарцаг ашиглах

(а) Саадыг тэмдэглэхэд ашиглаж байгаа дарцаг нь:

- (1) тухайн байгууламжийн эргэн тойронд, дээр нь, эсхүл хамгийн өндөр цэгийг тойруулж байрлуулна;
- (2) тухайн саадын учруулж болох аюулыг нэмэгдүүлэхгүй байхаар байна.

(b) Том хэмжээтэй саад, эсхүл өөр хоорондоо ойр байрласан бүлэг саадыг тэмдэглэхэд дарцгийг ашиглаж байгаа бол 15 м-ээс ихгүй зай тутамд байрлуулна.

(c) Суурин саадыг тэмдэглэхэд ашиглаж байгаа дарцаг нь:

(1) 600 x 600 мм-ээс багагүй хэмжээтэй;

(2) улбар шар өнгөтэй, эсхүл хоёр гурвалжин хэсгээс бүрдэх ба нэг нь улбар шар, нөгөө нь цагаан өнгөтэй, эсхүл нэг нь улаан, нөгөө нь цагаан өнгөний хослолтой байх ба эдгээр өнгө нь орчны суурь өнгөтэй уусаж байгаа бол өөр тод харагдахуйц өнгө ашиглаж болно.

(d) Хөдөлгөөнтэй саадыг тэмдэглэхэд ашиглаж байгаа дарцаг нь:

(1) 900 x 900 мм-ээс багагүй хэмжээтэй;

(2) дөрвөлжин хээтэй байна:

(i) тэгш өнцөгтийн талууд нь 300 мм-ээс багагүй;

(ii) тэгш өнцөгт бүр нь өөр хоорондоо ялгагдах эрс тэс, тод өнгөтэй ба суурь өнгөнөөсөө ялгарч харагдахаар байна;

(iii) орчны суурь өнгөнд уусахаас бусад тохиолдолд, улбар шар ба цагаан, эсхүл улаан болон цагаан өнгөөр хослуулан.

В.7. Саадын гэрэл ашиглах

(a) Саадыг гэрэлтүүлэх шаардлагатай бол бага, дунд, эсхүл өндөр тодорцтой, эсхүл эдгээр саадын гэрлийг хослуулж болно.

(b) Гэрлийн тодорц нь саадын аюул учруулах овор хэмжээг нэмэгдүүлэхээргүй байна.

(c) Бага тодорцтой саадын гэрлийн хэмжээ нь хангалтгүй, эсхүл холоос танигдах тусгай анхааруулга шаарддаг бол дунд, эсхүл өндөр тодорцтой саадын гэрлийг ашиглана.

(d) Том овор хэмжээтэй, эсхүл 45 м-ээс өндөр саадыг тэмдэглэхдээ дунд тодорцтой саадын гэрлийг дангаар нь, эсхүл бага тодорцтой саадын гэрэлтэй хослуулан ашиглана.

(e) Өндөр тодорцтой саадын гэрэл нь өдөр шөнийн аль ч үед ашиглах зориулалттай байна.

(f) Өндөр тодорцтой саадын гэрлийг өндөр саадыг илэрхийлэхэд хэрэглэнэ, хэрэв саадын өндөр 150 м-ээс их бол.

В.8. Саадын гэрлийн байрлал

(a) Гэрэлтүүлэг шаардлагатай бол саадын оройн цэг дээр нэгээс доошгүй саадын гэрэл байрлуулах ба хэрэв яндан хэлбэрийн байгууламж бол бохирдлыг багасгах зорилгоор өндрийн гэрлийг оройн цэгээс доош байрлуулна.

(b) Саадын орой нь хүрээлсэн газрын түвшнээс 45 м-ээс өндөр бол гэрлийг саадын дундах түвшинд дараах байдлаар байрлуулна:

(1) өндрийн гэрэл болон газрын түвшний хооронд аль болох тэнцүү зайд байхаар;

(2) хэрэв бага, эсхүл дунд тодорцтой гэрлийг ашиглах бол хоорондоо 45 м-ээс холгүй зайд байхаар.

(с) Өндөр тодорцтой гэрлийг саадын дээр ашиглах бол саадын гэрэл нь хоорондоо 105 м-ээс холгүй зайтай байна.

(d) Тэмдэглэсэн байх түвшний гэрлийн тоо болон байрлал нь саадын азимутын өнцгийг тэмдэглэсэн байна.

(е) Саадын дээр байрлах гэрэл бүх чиглэлд өөр байгууламжаар халхлагдсан тохиолдолд нэмэлт, эсхүл орлох гэрлийг саадын дээр, тухайн саадын ерөнхий байдлыг харагдахаар байрлуулна.

(f) Өндрийн гэрлийг дараах байдлаар байрлуулна:

(1) саадыг хязгаарлах гадаргуугаас илүү гарсан саадын үзүүр, эсхүл булан бүр харагдахаар;

(2) далайн түвшнээр хамгийн өндөр илүү гарсан саадын үзүүр, эсхүл булан бүр харагдахаар;

(3) яндан хэлбэрийн байгууламж бол түүний оройгоос доош 1,500-3,000 мм-ийн хооронд (Зураг В.2 ба В.3);

(4) босоо цамхаг, эсхүл антен бол оройдоо өндөр тодорцтой саадын гэрэлтэй байх ба, гэхдээ хэрэв энэ нь тохиромжгүй бол хамгийн өндөр боломжтой цэгт түүнийг байрлуулах бөгөөд цагаан өнгийн дунд тодорцтой саадын гэрлийг оройн цэгт бэхэлнэ.

(g) Том хэмжээтэй саад, эсхүл өөр хоорондоо ойр байрласан бүлэг саадыг:


(1) тухайн саадын ерөнхий байдал болон овор хэмжээг илэрхийлэхээр саадыг хязгаарлах гадаргуугаас хамгийн өндөр саадын үзүүр, эсхүл булан бүрийн өндрийн гэрэл харагдах хэлбэрээр байрлуулна;

(2) хэрэв хоёр, эсхүл түүнээс олон булангууд нь ижил өндөртэй бол буултын талбайд хамгийн ойр байрлах буланд гэрлийг байрлуулна;


(3) бага тодорцтой гэрэл шаардлагатай бол хоорондоо 45 м-ээс холгүй зайтай байна;

(4) дунд тодорцтой гэрэл шаардлагатай бол хоорондоо 90 м-ээс холгүй зайтай байна.

Зураг В.2 - Өндөр байгууламж дахь гэрэлтүүлэг, тэмдэглэгээ байрлуулах жишээ




H - Зурагт үзүүлснээр 45 м-с бага.
Үүнээс өндөр бол гэрлүүдийг дунджаар доорх томъёоны дагуу нэмж байрлуулж болно.



$$\text{Гэрлийн тоо хэмжээ} = N = \frac{Y \text{ (метр)}}{45}$$

$$\text{Гэрэл хоорондын зай} = X = \frac{Y}{N} \leq 45 \text{ м}$$



$A, B = 45 \text{ м} - 90 \text{ м}$
 $C, D, E < 45 \text{ м}$

Зураг В.3 - Байгууламжийн гэрэлтүүлэг

В.9. Бага тодорцтой саадын гэрлийн үзүүлэлт

(а) Суурин саадын бага тодорцтой саадын гэрэл нь дараах тодорцтой суурин улаан гэрэлтэй байна:

- (1) түүнийг суурилуулсан орчноос тод харагдахуйц;
- (2) улаан гэрлийн 10 канделаас багагүй.

(б) Хөдөлгөөнт саадын бага тодорцтой саадын гэрэл нь:

(1) шар өнгөтэй, эсхүл хэрэв шар өнгө тохирохгүй бол улаан өнгөтэй;

(2) анивчих давтамж нь минутанд 60-90 удаа;

(3) шар, эсхүл улаан гэрлийн идэвхтэй тодорц нь 40 канделаас багагүй байна.

В.10. Дунд тодорцтой саадын гэрлийн үзүүлэлт

Дунд тодорцтой саадын гэрэл нь:

(1) өндөр тодорцтой саадын гэрэлтэй хамт ашиглах бол цагаан өнгөтэй байхаас бусад тохиолдолд улаан өнгөтэй;

(2) анивчих давтамж нь минутанд 60-90 удаа;

(3) улаан гэрлийн идэвхтэй тодорц нь 1,600 канделаас багагүй

байна.

В.11. Өндөр тодорцтой саадын гэрлийн үзүүлэлт

Өндөр тодорцтой саадын гэрэл нь:

- (1) цагаан өнгөтэй;
- (2) зэрэг анивчих давтамж нь минутанд 40-60 удаа;
- (3) татлаган тулгуурт цамхаг дээр суурилуулснаас бусад тохиолдолд, идэвхтэй тодорц нь дараах суурийн гэрэлтэлтээс шалтгаалан харилцан адилгүй байна:

Суурийн гэрэлтэлт	Идэвхтэй тодорц
500 кд/м2-с их	минимум 200,000 кд
50-500 кд/м2	20,000 кд ± 25%
50 кд/м2-с бага	2,000 кд ± 25%

Хавсралт С – Халхлах

(а) Нислэг үйлдэх агаарын зайд аюултай болохыг тогтоосон байгууламжийг хэрэв Дарга халхлагдсан гэж үзвэл тэмдэглэсэн, эсхүл гэрэлтүүлсэн байхыг шаардахгүй байж болно.

(b) Бусад байгууламжаас нам өндөртэй дараах байгууламжийг бусад байгууламжаар халхлагдсан гэж үзэж болно:

- (1) нислэг үйлдэх агаарын зайд аюултай болохыг тогтоосон;
- (2) саадын стандарт тэмдэглэгээ, эсхүл гэрэлтүүлгээр тэмдэглэсэн.


(с) Саадыг хязгаарлах гадаргууг огтолсон байгууламж нь халхлагдсан эсэхийг тодорхойлохын тулд нисэхийн судалгаа шаардлагатай байж болно.

(d) Халхалсан байгууламж нь байнгын суурин байна.


(е) Энэ зүйлийн (с)-ийн зорилгоор, арилжааны нислэгийн үйл ажиллагааны хэлбэр, төрөл, эсхүл нягтрал хэрхэн өөрчлөгдөж болохоос үл хамааран, зөвхөн хэрэв боломжит урт хугацааны хэтийн төлөвлөгөөнд түүнийг буулгах бодит бололцоо, боломж, эсхүл үндэслэл байхгүй бол тухайн байгууламжийг байнгын гэж ангилж болно.

(f) Халхлагдсан саад нь ойртолтын, эсхүл хөөрөлтийн гадаргууд, эсхүл шилжилтийн хажуу, эсхүл дотоод хэвтээ гадаргууд байгаа бол Зураг С.1 болон С.2-т үзүүлсэн халхалсан байгууламжийн шалгуурыг хангасан байна.

(g) Саад нь энэ зүйлийн (е)-д заасан бүсийн гадна байгаа тохиолдолд хэрэв халхалсан байгууламжаас 600 м-ээс дотогш байрлаж байгаа бол түүнийг халхлагдсан гэж үзэж болно.



Зураг С.1 - Ойртолт болон хөөрөх гадаргууг халхлах



Зураг С.2. - Шилжилтийн болон хэвтээ гадаргууг халхлах

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 7379 дүгээрт бүртгэв.

БУЛГАН АЙМГИЙН СЭЛЭНГЭ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ V ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 9 дүгээр
сарын 10-ны өдөр

Дугаар 05/04

Сэлэнгэ сум

СЭЛЭНГЭ СУМЫН БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫН ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.22 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.14 дэх заалт, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.6 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь.

1.Сэлэнгэ сумын бэлчээр ашиглалтын журмыг хавсралтаар баталсугай.

2.Бэлчээр ашиглалтын журмыг олон нийтэд сурталчилж, хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга (А.Ганбагана)-үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хөдөө аж ахуй, байгаль орчин, аялал жуулчлалын хорооны дарга гишүүдэд даалгасугай.

ДАРГА

Х.ХҮДЭРЧУЛУУН

*Булган аймгийн Сэлэнгэ сумын Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2025 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн
V хуралдааны 05/04 дүгээр тогтоолын хавсралт*

СЭЛЭНГЭ СУМЫН БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг журам

1.1.Бэлчээрийг орон нутгийн бэлчээрийн экологийн чадавхид суурилсан аргачлалаар улиралын хуваартай төлөвлөх, бэлчээрийн даац, багтаамжид тохируулан малын тоо толгойн зохистой хэмжээг бий болгож, бэлчээр байгалийн жамаараа нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх, зүй зохистой ашиглах, хамгаалахад нутгийн захиргаа, малчдын хооронд үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Газрын тухай хуулийн 50.1.1-т заасны дагуу бэлчээрийн төлөв байдал чанарыг хадгалах, хөрсний үржил шим буурах, бэлчээрийн ургамлын бүрхэвч талхлагдаж хөрс элэгдэх, эвдрэх, хуурайших, намагших, давсжих, бохирдохоос сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тодорхой хувийг бэлчээр ашиглагч малчин хариуцна.

1.3.Сумын нутаг дэвсгэрт Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Газрын тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангахад бэлчээр, ус ашиглагч малчид, бүлэг, аж ахуйн нэгж, байгууллагууд энэхүү журмыг мөрдлөгө болгон ажиллана.

Хоёр. Бэлчээр ашиглалтыг төлөвлөх

2.1.Бэлчээр ашиглалтыг төлөвлөхдөө дараах зарчмыг баримтлана.

2.1.1.Бэлчээрийн даац, багтаамж, экологийн чадавхид суурилах

2.1.2.Бэлчээр ашиглагчдын тэгш оролцоог хангах

2.2.Тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө /цаашид “Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө” гэх/ нь дараах шаардлагыг хангасан байна.

2.1.1.Бэлчээрийн төлөв байдал чанарт хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний /фотомониторинг гэх/ дүнд үндэслэсэн байх

2.2.2.Бэлчээрийг улирлаар ашиглах, сэлгэх, өнжөөх хуваарь гаргах

2.2.3.Тариалангийн талбайгаас 500 метрээс гадагш байх

2.2.4.Бэлчээр дэх уст цэг, хужир мараа бүхий газрыг нийтээр ашиглах нөхцөлийг бүрдүүлэх

2.2.5.Бэлчээр ашиглалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа гадаад улс, донор байгууллагын төсөл хэрэгжүүлэгч нь бэлчээр

ашиглалтын жилийн төлөвлөгөөг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэхэд баг, сумын Засаг даргатай хамтран ажиллаж болно.

Гурав. Бэлчээр ашиглагчдын эрх, үүрэг

3.1.Бэлчээр ашиглагч дараах эрх, үүрэгтэй.

3.1.1.Багийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулахад оролцох.

3.1.2.Бэлчээр өнжөөх, чөлөөлөх, сэлгэх, отор нүүдэл хийх талаар гаргасан сум багийн Засаг даргын шийдвэрийг дагаж биелүүлэх.

3.1.3.Малын тоо толгойн татварыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоосон хэмжээгээр хуулинд заасан хугацаанд төлөх.

3.1.4.Гаднаас дур мэдэн отрын айл, мал сүргийг зөвшөөрөлгүй оруулж, өвөлжөө, хаваржаа, хот бууцыг дамжуулан ашиглуулахгүй, бэлчээр хашихгүй байх.

3.1.5.Бэлчээр, хашаа, саравч, бууц, усны эх үүсвэрийг бохирдуулахгүй, малын сэг зэм, хог хаягдлыг цэвэрлэж, хортон мэрэгчтэй тэмцэх, сумын мал эмнэлгээр ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэж устгах.

3.1.6.Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд тусгасан бэлчээр ашиглалтын улиралын хуваарьт бэлчээрээс өөр бэлчээрт дур мэдэн нутаглахгүй байх үүрэгтэй.

3.1.7.Энэ журмын 5.2.6 –д заасан гадны малчин өрхөд Бэлчээр ашиглуулсаны жилийн төлбөрийн хэмжээг Засгийн газрын 2018 оны 182 -р тогтоолоор тогтоосон хувь хэмжээгээр тооцно. Бэлчээрийн төлбөрийг тооцохдоо Газрын төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 –т заасан итгэлцүүрээр тооцно.

3.1.8.Энэ журмын 2.2.3 -д заасан зайд мал бэлчээхгүй, оторлохгүй, хашаа саравч барихгүй байх.

3.1.9.Хадлан, таримал ургамлыг мал, тэжээвэр амьтнаас хамгаалах арга хэмжээг Малчид Тариаланчдын Гурвалсан гэрээгээр зохицуулна.

3.1.10.Газрын тухай хуулийн 53.4-ыг үндэслэн бэлчээрийн зохих ургацтай хэсгийг хадлангийн зориулалтаар ашиглах иргэн, ААН, байгууллага сумын Засаг даргатай гэрээ байгуулан хадлан бэлтгэж болно.

3.1.11.Өөрийн эзэмшлийн өвөлжөө, хаваржааны газрын эзэмших эрхийг бусдад шилжүүлсэн бол Газрын тухай хуулийн 53.5 -д зааснаас бусад тохиолдолд өмнө нь хадлан бэлтгэдэг байсан бэлчээрийн талбайг Газрын тухай хуулийн 53.2, 53.4 д заасны дагуу шийдвэрлэнэ.

Дөрөв. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1.Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.1.1.Сумын засаг даргын өргөн мэдүүлсэн сумын бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэлэлцэн баталж хэрэгжилтэнд хяналт тавина.

4.1.2.Бэлчээр ашиглалтын журмыг үлгэр жишээ мөрдөж буй малчдыг бодлогоор дэмжих, шагнаж урамшуулах

4.2.Сумын Засаг дарга дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.2.1.Бэлчээр болон ус ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг багийн Засаг даргатай хамтран зохион байгуулах, шалгах, тайлагнах

4.2.2.Багийн Засаг даргын жилийн ажлыг үнэлэхдээ энэ журмын хэрэгжилтийн үр дүнг тооцох

4.2.3.Гол, горхи, булаг, шандын эх ундрага, хадлангийн болон тариалангийн талбай хамгаалах, нөхөн сэргээх, сайжруулах арга хэмжээ зохион байгуулах

4.2.4.Гантай эсхүл өвөлжилт хүндэрсэн өөрийн сумын багаас бэлчээрийн даац хүрэлцээтэй багийн нутаг дэвсгэрт айл өрх мал сүргийг тухайн багийн Засаг даргатай зөвшилцөн оруулах шийдвэр гаргах

4.2.5.Бэлчээр ашиглагчдад нэг наст болон олон наст ургамал тариалах, тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэх зэрэгт бодлогоор дэмжих, арга зүйгээр хангах

4.2.6.Гадны малчидтай “Бэлчээр ашиглуулах гэрээ” байгуулна.

4.2.7.Газрын тухай хуулийн 52.2т заасны дагуу тухайн жилийн бэлчээрийн гарц иргэдийн саналыг харгалзан өвөлжөө, хаваржааны бэлчээрийг чөлөөлөх, мал оруулах хугацаа болон отроор ирсэн малчдад Болзолт гэрээгээр бэлчээр ашиглуулж болно.

4.2.8.Бэлчээрт мониторингийн судалгаа хийх, үүлэнд нөлөөлөх генератор байрлуулах саналыг аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний газарт хүргүүлэх

4.3.Багийн Иргэдийн Нийтийн Хурал дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.3.1.Энэ журмын 2.2-д заасны дагуу Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж хурлаараа хэлэлцэн жил бүрийн 5, 9 сарын 5-нд багтаан сумын ИТХ-д хүргүүлэх

4.3.2.“Бэлчээр ашиглалтын журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа сумын Засаг даргад уламжлах, бэлчээр, усны маргаантай асуудлыг шалгаж, шийдвэрлэх

4.3.3. Уг журмын хэрэгжилтийн талаарх багийн Засаг даргын тайланг хэлэлцэж, дүгнэж, шийдвэр гаргах

4.3.4. Багийн иргэдийн нийтийн хурлаас гарсан саналыг тухайн багийн бэлчээр ашиглалтын хуваарийн төсөлд тусгуулах, усан хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах

4.4. Багийн Засаг дарга дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.4.1. Сумын тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг үндэслэн өөрийн багийн нутаг дэвсгэрт тусгайлан болон нийтээр ашиглах бэлчээр усны хуваарь, заагийг газрын зурагт хот айл, малчдын бүлэг (цаашид бүлэг гэх) тус бүрээр нарийвчлан үйлдэн Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлж төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах

4.4.2. Гадны нутаг (отор)-аас гэрээ, зөвшөөрөл, мал эмнэлгийн үйлчилгээний бичиггүй орж ирсэн малчидтай нэн даруй уулзаж, шаардлага өгч, нүүлгэх, нутаг бэлчээр олгохгүй байх

4.4.3. Бэлчээрийн хөнөөлт мэрэгчид, хортон шавьжтай тэмцэх ажлын хүрээнд тандалт судалгааг малчид болон малчдын бүлэгтэй хамтран хийж, сумын Хөдөө аж ахуйн тасаг болон нийтийг хамруулан тэмцэх ажлыг зохион байгуулах

4.4.4. Малын тоо толгойг бэлчээрийн даацад нийцүүлэхэд чиглэсэн сүргийн зохистой бүтэц, харьцаа, үүлдэр угсаа, чанарыг сайжруулахад анхаарч ажиллах, мал эмнэлгийн тусламж үйлчилгээнд малчдыг бүрэн хамруулах

4.4.5. “Бэлчээр ашиглалтын журам” зөрчсөн этгээдэд хугацаатай мэдэгдэх хуудас өгч сумын Засаг даргад нэн даруй мэдэгдэх

4.4.6. Бэлчээрийг хуваарийн дагуу чөлөөлөөгүй этгээдийг албадан нүүлгэж, гарсан зардлыг төлүүлэх

4.5. Сумын мал эмнэлэгийн тасгийн улсын байцаагч дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.5.1. Сумын нийт мал сүргийг элдэв паразит шимэгч хорхой халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг мал эмнэлгийн нэгжүүдтэй хамтран зохион байгуулах

4.5.2. Малын шилжилт хөдөлгөөн мал амьтны гаралтай хүнсний болон түүхий эд бүтээгдэхүүний ариун цэвэр, аюулгүй байдалд баталгаажуулалтын хяналт, тогтмол хийх

4.5.3. Гадны нутгаас орж ирсэн болон отрын малд гарал үүсэл, эрүүл ахуй, мал эмнэлэгийн тасгийн байцаагчийн тодорхойлолтыг үндэслэх, шаардлагатай гэж үзвэл ариутгал халдваргүйжүүлэлт хийж сумын хилээр нэвтрүүлэх

4.6. Сумын Хөдөө аж ахуйн тасаг дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.6.1.Малчдад бэлчээр ашиглалтын ач холбогдлыг ойлгуулж, мэдлэг олгох, доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх сайжруулах талаар сургалт зохион байгуулах бэлчээрийг зөв зохистой ашиглах дадалтай болгох

4.6.2.Бэлчээрийн төлөв байдал, чанарт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэх, бэлчээр ашиглах, сэлгэх, өнжөөх хуваарийг боловсруулах

4.6.3.Бэлчээрийг хамгаалах, байгалийн жамаараа нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх, бэлчээр дэх уст цэг, хужир мараа бүхий газрыг нийтээр ашиглах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг хэрэгжүүлэх

4.6.4.Нөөц нутаг бэлчээрийг ашиглах зайлшгүй шаардлага гарсан үед санал боловсруулж сумын Засаг даргад танилцуулах

4.6.5.Бэлчээрийн хөнөөлт мэрэгчид хортон шавьжтай тэмцэх ажлыг малчдын оролцоотой зохион байгуулах

4.6.6.Малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэхэд чиглэсэн сүргийн зохистой бүтэц, харьцаа, сүргийн эргэлтийг оновчтой зохион байгуулах, бэлчээрийн даац, төлөв байдлын үнэлгээнд тулгуурлан малын тоо, төрөл сүргийн бүтцийг тохируулах ажлыг зохион байгуулах

4.7.Сумын Цаг уурын өртөө дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.7.1.Сумын фотомониторингийн цэгийн тоо, бэлчээрийн даац тодорхойлсон дүнгийн хамт жил бүрийн 8 дугаар сарын 20-ны дотор сум, багийн Засаг даргад хүргүүлэх

4.7.2.Иргэдийг Цаг агаарын урьдчилсан мэдээллээр хангах, масс мэдээ илгээх

4.8.Газрын даамал дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.8.1.Сумын нийт бэлчээрийн талбайн хэмжээ, байршлыг газрын мэдээллийн нэгдсэн санд бусад ангилалын газартай давхцуулахгүйгээр бүртгэх

4.8.2.Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний төслийг боловсруулахад оролцож багийн иргэдийн Нийтийн Хуралд саналаа хүргүүлэх

4.8.3.Газрын тухай хуулийн 58.5 заасны дагуу бэлчээр, хадлангийн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг 5 жил тутамд мэргэжлийн байгууллагаар хийлгэх

4.8.4.Сумын нөөц бэлчээрийн хэмжээ, өвөлжөө, хаваржаа, худаг уст цэгийн байршлын мэдээллийн сан үүсгэх, тогтмол шинэчлэх

Тав. Маргаан шийдвэрлэх хохирол нөхөн төлүүлэх

5.1.Бэлчээр ашиглах асуудлаар гарсан маргааныг Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.10 дахь хэсэгт заасны дагуу Багийн Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэж зохицуулна. Эс тохиролцсон тохиолдолд сумын Засаг дарга шийдвэрлэнэ.

5.2.Бэлчээрт учирсан хохирлыг нөхөн төлөх асуудлыг Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар зохицуулна.

5.3.Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.

Зургаа. Журам хүчин төгөлдөр болох

6.1.Энэхүү журмыг Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2-т заасны дагуу захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтэлсний дараа хүчин төгөлдөр болно.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд
2025 оны 10 дугаар сарын 09-ний өдөр хүлээн авсан.

САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 9 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар А/172

Улаанбаатар
хот

ТУШААЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.5 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Журам шинэчлэн батлах тухай” Сангийн сайдын 2024 оны А/205 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Санхүүгийн тайланг цахим хэлбэрээр хүргүүлэх, хүлээн авах, тайлангийн мэдээллийг ашиглах журам”-д доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/2 дугаар зүйлийн 2.19, 2.20 дахь хэсэг:

“2.19.Тухайн тайлант үеийн эхний үлдэгдэл нь өмнөх оны сүүлд “хүлээн авсан” төлөвтэй тайлангийн эцсийн үлдэгдэл байна.

2.20.Энэ журмын 2.18-д заасны дагуу гэрээ байгуулсан аудитын хуулийн этгээд тайлагнагч байгууллагын аудитын дүгнэлт болон тайланг системд оруулсан тохиолдолд тайлагнагч байгууллагын хагас жилийн санхүүгийн тайлант үед “холбогдох” товч идэвхжиж, тайланг шивэх үйлдлийг эхлүүлнэ.”

3/3 дугаар зүйлийн 3.9 дэх хэсэг:

“3.9.Харилцагч санхүүгийн байгууллагын холбогдох асуудал хариуцсан газар нь энэхүү журмын 3.5-д заасан аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланг хянах саналыг Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар (цаашид “НБББГ” гэх)-т тухайн жилийн 01 дүгээр сарын 05-ны өдрийн дотор жагсаалтаар хүргүүлсэн байна.”

4/5 дугаар зүйлийн 5.5.5 дахь заалт:

“5.5.5.Компанийн тухай хуулийн 5.11-д заасан хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигч.”

2.Мөн журмын 2.13.6 дахь заалтын “оруулсан” гэсний дараа “, тус мэдээллийг ерөнхий нягтлан бодогч зөвшөөрсөн” гэж, 2.18 дахь хэсгийн “дүгнэлтийг” гэсний дараа “болон тайланг Аудитын тухай хуулийн 10.2.1-10.2.3 болон Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасан хугацаанд” гэж, 5.5 дахь хэсгийн “дараах” гэсний өмнө “болон excel хэлбэрээр” гэж, 5.5.2 дахь заалтын “тухайн” гэсний өмнө “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 9.3-т заасны дагуу” гэж тус тус нэмсүгэй.

3.Мөн журмын 3.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3.5.Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой, Засгийн газартай бүтээгдэхүүн хуваах, тогтвортой байдлын болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан, эсхүл тусгайлан мэдээлсэн байгууллагуудын санхүүгийн тайланг хянаж, хүлээн авахдаа системд байршуулсан тойрох хуудсыг харилцагч санхүүгийн байгууллагын холбогдох асуудал хариуцсан газруудаар хянуулсан байна.”

4.Мөн журмын 2.2.1 дэх заалтын “бүртгэлтэй” гэснийг ““татан бууж байна, хориг тавьсан, хэвийн” гэсэн төлөвтэй” гэж, 2.8, 2.9, 3.4, 4.1.1, 4.1.2, 7.1.3 дахь хэсгийн “баталгаажсан” гэснийг “хүлээн авсан” гэж, 2.15 дахь хэсгийн “баталгаажуулаагүй” гэснийг “хүлээн авсан төлөвт шилжээгүй” гэж, 8.1 дэх хэсгийн “Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар (цаашид “НБББГ” гэх)” гэснийг “НБББГ” гэж тус тус өөрчилсүгэй.

5.Мөн журмын 2.9 дэх хэсгийн “тохиолдолд” гэснийг хассугай.

6.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Б.Болормаа/-т үүрэг болгосугай.

САЙД

Б.ЖАВХЛАН

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд
2025 оны 10 дугаар сарын 15-ны өдөр хүлээн авсан.

ЗАВХАН АЙМГИЙН ТҮДЭВТЭЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 9 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар А/120

Ойгон

ЗАХИРАМЖ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТУХАЙ


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйл 66.1, 66.3 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 48 дугаар зүйлийн 48.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидаг согтуурахтай тэмцэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 заасан “Аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч харьяалах нутаг дэвсгэртээ согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газрын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг тогтооно” гэсэн заалтыг зөрчсөн сумын Засаг даргын 2018 оны А/66 дугаар захирамж, 2025 оны А/10 дугаар захирамжийг тус тус хүчингүй болгосугай.


2.Захирамжийг хүчингүй болгосон тэмдэглэгээг зохих журмын дагуу хийхийг Архив, албан хэрэг хөтлөгч (Ч.Цэрэндолгор)-т даалгасугай.

ДАРГА

Х.САРУУЛ-ЭРДЭНЭ



10/2/50



*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд
2025 оны 10 дугаар сарын 15-ны өдөр хүлээн авсан.*

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 10 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар А/261

Улаанбаатар
хот

ТУШААЛ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн Иргэний нисэхийн дүрмийг шинэчлэн баталж байгаатай холбогдуулан Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын 2006 оны “Дүрэм батлах, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 03 дугаар тушаал, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2009 оны “Дүрэм батлах, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 252 дугаар тушаал, 2010 оны “Дүрэм батлах, дүрэмд өөрчлөлт оруулах тухай” 335 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

ТЭМДЭГЛЭЛ